



# СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.03.05 №09 (10686)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

## САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААН БОЛОВ



Батлан хамгаалах яамны дэд сайд Т.Дуламдоржийн тэргүүлсэн Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2020 оны анхдугаар хуралдаан 3 дугаар сарын 2-ны өдөр

болж, үндсэн дөрвөн асуудлыг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргалаа. Тухайлбал, улсын санхүүжилтээр 2021 оноос эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслийн захиалгын санал болон

БХЯ, ЗХЖШ-ын захиалгаар Батлан хамгаалахын сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудаар 2020 онд гүйцэтгүүлэх судалгааны ажлын даалгавруудын төслийг тус тус хэлэлцсэн юм.

## ДАЛАЙД ДУСАЛ НЭМЭР



Батлан хамгаалах яамны Ахмадын хорооны санаачилга, 500 гаруй ахмадын сэтгэлийн дэмээр цугларсан нэг сая төгрөгийн хандивыг тус хорооны удирдах зөвлөлийн гишүүн, бэлтгэл хурандаа Ц.Энхбат, нарийн бичгийн дарга, чөлөөнд байгаа дэд хурандаа

Г.Батмөнх нар Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч, хурандаа С.Батболдод гардуулан өглөө. Аль ч цаг үед өргөсөн тангарагтаа үнэнч байж тэргүүн эгнээнд явдаг цэргийн эмч, сувилагч, ажилтан алба хаагчид энэ удаад ч мөн адил дэлхий нийтэд тархаад

байгаа цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажилд идэвх санаачилгатай оролцож байгаад талархаж буйгаа энэ үеэр илэрхийлэв. Халдвар тархсан улс орнуудаас ирсэн 100 гаруй иргэд тус эмнэлэгт тусгаарлагдсан бөгөөд Цэргийн төв эмнэлгийн томилогдсон бүрэлдэхүүн ажиллаж байгаа юм.

Энэ үеэр хурандаа С.Батболд Ахмадын хорооны гишүүдэд хандан "Та бүхний өгсөн энэхүү хандивыг тусгаарлагдаж байгаа иргэд болон тухайн тасагт ажиллаж буй алба хаагчдаа зориулах болно. Эхний ээлжинд нэг удаагийн амны хаалт, бээлий, нөмрөг, хувцас хэрэглэл худалдан авна. Эрүүл мэндийн яамнаас хангалт хийж байгаа ч хүрэлцээ муу, бид өөрсдийн нөөц бололцоогоор үйл ажиллагаагаа явуулж байгаа. Тиймээс та бүхэндээ маш их баярлалаа" гэлээ.

## ЭХ ОРОНДОО АМНЫ ХААЛТ ИЛГЭЭЖЭЭ



Дэлхий нийтэд тархаад байгаа шинэ төрлийн вирусийн эсрэг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд, хилийн чанадад суралцаж буй сонсогчид гээд олон тооны цэргийн алба хаагч санаачилга гаргаж, өөрсдийн нөөц бололцоог

ашиглан хүмүүнлэгийн ажилд оролцож байна.

Тухайлбал, ОХУ-ын Москва хотын Цэргийн их сургуулийн хоёрдугаар дамжааны сонсогч, дэд ахлагч Г.Энхжин, Воронеж хотын Агаарын

нисэхийн сургуулийн дөрөвдүгээр дамжааны сонсогч, дэд ахлагч Н.Сүмбэрэл нарын санаачилгаар Монгол Улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах байгууллагаас ОХУ-ын 13 хотод суралцаж байгаа 265 офицер, сонсогч нарын хандиваар бүрдсэн 670 ширхэг "FFP1" амны хаалтыг эх орондоо илгээхээр Монгол Улсаас ОХУ-д сугаа Элчин сайдын яамны цэргийн атташэд хүлээлгэн өгчээ. Коронавирусийн дэгдэлттэй холбоотойгоор Монгол Улсад урьдчилан сэргийлэх нэг удаагийн амны хаалтын хүрэлцээ дутмаг байгаагаас үүдэн өргөсөн тангарагтаа үнэнчээр албан үүргээ гүйцэтгэж байгаа алба хаагчдаа өчүүхэн сэтгэлийн дэм болох үүднээс энэхүү аяныг санаачлан хэрэгжүүлсэн юм.

Ахмад Б.УРАНБААТАР

## ТЭСГИМ ХҮЙТЭНД Ч ТЭД ШҮХРИЙН БУУЛТАА ХИЙЛЭЭ

Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн 2019-2020 оны сургуулийн жилийн төлөвлөгөөт шүхрийн өвлийн дадлага, буултаа өнгөрсөн сард Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн байрлалын районд гурван хоногийн хугацаатай амжилттай зохион байгууллаа.

Энэ удаад 154 цэргийн

алба хаагч давхардсан тоогоор 751 буулт хийсэн ба тэдний дотор анхлан буугч 35 цэргийн алба хаагч шүхэрчдийн эгнээнд нэгдэж, шүхрийн спортын 3 дугаар зэрэг эзэмшлээ. Мөн найман цэргийн алба хаагч дөрвөлжин шүхрээр бууж ур чадвараа ахиулав. Шүхрийн дадлага, буултын үеэр Зэвсэгт хүчний Жанжин штабын

орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар энэхүү нислэг буултын явцтай танилцаж, цаг агаарын хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа шүхэрчдээрээ бахархаж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ эр зориг, тэсвэр хатуужил шаардсан хөдөлмөр болохыг нь онцолсон юм.

Ахмад Д.МӨНХ-ӨНӨР

## КОРОНАВИРУСИЙН ТАРХАЛТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭС ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Дэлхий нийтэд тархаад буй шинэ төрлийн коронавирсийн нөхцөл байдал, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын удаа дараагийн хурлын шийдвэрийн дагуу Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабаас олон талт арга хэмжээг тухай бүрд нь хэрэгжүүлээд байна. Тухайлбал, зохион байгуулалтын ажлын чиглэлээр "Онцгой нөхцөл бий болсон үед цэргийн хүчээр дэмжлэг үзүүлэх Зэвсэгт хүчний нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу онцгой нөхцөл бий болсон үед үүрэг гүйцэтгэх "ЗХЖШ-ын удирдлагын шуурхай бүлэг"-ийн бүрэлдэхүүнийг тодотгож, шаардлагатай удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан, удирдамж, үүрэг чиглэлээр хангаад байна. Мөн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын томилоот бүлгүүдэд үүрэг, захирамж өгөх, бэлтгэлийг нь хангуулах, бүх төрлийн хангалтыг зохион байгуулах чиглэлээр ЗХЖШ-ын даргын албан даалгавруудыг зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хүргүүлэн хэрэгжилтийг нь ханган ажиллаж байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлигийн дагуу Зэвсэгт хүчний хэмжээнд Сар шинийн баярт зориулсан олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байх, бие бүрэлдэхүүнийг албаны болон хувийн ажлаар хөдөө, орон нутагт зорчихгүй байх зөвлөмжийг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хүргүүлэн мөрдлөг болгон ажиллалаа. Мөн "Зэвсэгт хүчний 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу явагдах нэгдсэн хэргийн сургууль, дадлагыг хязгаарлаж, цугларалт, дамжаа, тэмцээн уралдаануудыг хойшлуулан шинэ төрлийн коронавирсийн тархалтаас урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлын талаар бодит мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Түүнчлэн цэргийн алба хаагч, ажилтнуудыг албан томилолт болон хувийн журмаар гадаад орнуудад 2020 оны 2 дугаар сарын 27-ноос 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд зорчуулахгүй байх, халдварын голомт бүхий орнуудад албан томилолт, сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн холбогдох байгууллагын үзлэг, шинжилгээнд хамруулах, цэргийн алба хаагчдын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж хүрэлцээг тогтвортой байлгах, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авахыг анхааруулаад байна.

Мөн Улсын онцгой комиссын 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дөрөвдүгээр хурлын тэмдэглэлийн дагуу амны хаалтын улсын нөөцийн бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор цэргийн оёдлын "Бөртэ" ТӨААТҮГ 45000 ширхэг амны хаалтыг оёж хүлээлгэн өгсөн аж.

Түүнчлэн коронавирсийн халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед нийслэлийн хэмжээнд Цэргийн төв эмнэлгийг тусгайлан бэлтгэх ажлын хүрээнд тус эмнэлгийг халдварын эмнэлгийн зориулалтаар ашиглах, 570 өвчтөн хүлээж авах нөхцөлийг бүрдүүлж, бэлтгэлийг нь хангууллаа. Цэргийн төв эмнэлгийг халдварын эмнэлгийн зориулалтаар ашиглах бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн боловсруулж, шаардлагатай үед ажиллах алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан эмч, ажилтнуудын сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, эмнэлгийн харуул, хамгаалалтыг зохион байгуулах бүдүүвчийг боловсруулан батлуулсан бөгөөд 2 дугаар сарын 27-ны өдөр Япон улсаас ирсэн 100 гаруй хүний Цэргийн төв эмнэлэгт байршуулан урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авчээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас коронавирсийн тархалтын талаар гаргасан зөвлөмж, мэдээллийг бие бүрэлдэхүүнд шуурхай хүргэх, уг халдварын хор хөнөөлийг ухуулан ойлгуулах ажлыг зохион байгуулж, сэжигтэй тохиолдол илэрсэн үед анги, байгууллагын эмнэлгийн байранд шаардлагатай үед ашиглах тусгаарлах өрөө, бүх төрлийн эм, ариутгалын бодисыг бэлтгэж, орчны ариун цэвэр, эрүүл ахуйн байдалд тогтмол үзлэг шалгалтыг хийж байна. Мөн амьсгалын замын өвчлөл, коронавирсийн тандалтын хуудсыг боловсруулан Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хүргүүлсэн бөгөөд томилоот эмнэлгийн шуурхай бүлгийг үүрэг, зааварчилгаагаар хангах, шаардлагатай үед эмнэлгийн тусламжийн цүнх, халдвар хамгааллын хувцсыг бэлэн байлгах, бие бүрэлдэхүүнд урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулж хяналт тавих зэрэг ажлыг эрчимжүүлж байна.

Түүнээс гадна зах зээлд нэг удаагийн амны хаалт хүрэлцээгүй байгаатай холбогдуулан ХӨСҮТ-өөс гаргасан зөвлөмжийн дагуу Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд амны хаалт хийх самбай даавууг Зэвсэгт хүчний ангиудад татан төвлөрүүлж, амны хаалт хийж, ашиглах, ариутгах талаар зааварчилгаа өгч ажиллаж байна.



# ИХ ҮЙЛСИЙН ЭЗЭД



Бетоны сорьц авч байгаа байдал



Бетон зуурмагийн ажил

Шинэ бүхэн хуучнаа халж, ирж буй болгон ирээдүйн сайн сайхан бүхнийг даллан дуудах нь энэ орчлонгийн эргэх жам. Цаг хугацаа гэж хэнд ч үл захирагдах "их эзэн хаан" улирсан бүхнийг ардаа үүрч, утгсан бүхнийг урдаа тэвэрч угтах. Эл цагийн урсгал дунд элж мартагдах зүйл олон ч элж мартагдах нь бүү хэл эхэлж, өрнөж, өөдөлж дэвшиж, өргөжиж тэлсэн үйл арвин.

Ийм нэгэн их үйлсийн эзэд бол барилгачид. Тэд хоцрогдсон мал аж ахуйгаас өөр эрхлэх юмгүй асан улс оронд үлгэрт гардаг гандирсын хотыг гардан бүтээж гандашгүй их алдар гавьяаг газрын хөрсөн дээр дархалсан бөлгөө. Эдний дунд байгуулагдсан цагаасаа эхлээд эх орныхоо бүтээн байгуулалтын үйлсэд үнэлж баршгүй хувь нэмэр өргөсөн Барилгын цэргэг хэмээх их айлын байгуулсан гавьяаг хэмжиж, хэлцэж баршгүй.

Тэр их айлын ирээдүй өөд өгсөж, их нүүдлийн тэнгийн ачаа тээж, жингийн цуваа

хөтөлж яваа залгамж халаа бол Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, хошууч генерал Х.Жүгдэрнамжил агсны нэрэмжит Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 017 дугаар ангийн хамт олон. Шинэ бүтэц, зохион байгуулалтад шилжиж, хуучин уламжлалаа сэргээхээр байлдааны тугаа хүлээж аваад нэг их удаагүй ч барьж босгосон, засаж сайжруулсан барилгын тоо нь арван хуруунаас аль эрт давж, анги, салбар, аймаг, сум бүрд шахуу амжилт бүтээл нь оршсон. Энэ хамт олон хамгийн сүүлд буюу өнгөрсөн жил Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын барилга угсралтын ажлыг мэргэжлийн өндөр түвшинд үлгэр жишээ гүйцэтгэж, өөрсдийнхөө ур чадварыг өргөн түмнээрээ хүлээн зөвшөөрүүлсэн.

Тэд одоо "Шинэ төмөр зам" төслийн ажлын хүрээнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416,2 км төмөр замын доод бүтцийн ус өнгөрүүлэх угсармал төмөр бетон хоолойг эх орондоо

үйлдвэрлэх их үйл хэрэгт шамдан ороод байна. Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэж, хийц эдлэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг БНХАУ-аас захиалан авчирч угсралт тохируулгын ажлыг гүйцэтгэж, гуравдугаар цахилгаан станцаас бүтээгдэхүүний хатаалгад ашиглах өндөр хэмийн халуун уурын шугам хоолой татаж, материалын орц нормыг зураг, төслийн дагуу тогтоож, хэрэгцээнд зориулагдах материалаа сонгон шалгаруулж ажлаа эхлүүлжээ.

Үндсэн түүхий эд болох бэхлэгээний төмөр хийцийн материал, цемент зэргээ дотоодын үйлдвэрлэлээ дэмжих зорилгоор "Мон цемент", "Улаанбаатар менежмент" зэрэг барилгын материалын үйлдвэрээс татан авч ашиглаж байгаа нь Монгол Улсын хөгжил дэвшилд өчүүхэн ч атугай хувь нэмрээ оруулах санаачилгаас үүдэлтэй. Үйлдвэрийн анхны бүтээгдэхүүнүүд нь туршилтаар онц сайн чанарын үнэлгээ авсан

нь мөн хамт олны цаашид ихийг хийж бүтээх урам зориг нэмсэн бахтай сайхан үйл болсон ба өдөрт 10 хэвээр 10 ширхэг, есөн метр урт, 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 5 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд 1042 ширхэг, 1981 метр урт угсармал төмөр бетон хоолойг үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байгаа нь төмөр замын бүтээн байгуулалтын ажилд төдийгүй улс орны эдийн засагт тодорхой хэмжээний үр ашгаа өгөх тооцоо судалгаан дээр үндэслэж байгаа аж. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх зохих шаардлагад бүрэн нийцсэн өндөр чанарын зуурмаг бэлдмэлээс сорьц тодорхойлох шоо авч "Барилга архитектор корпораци"-ын итгэмжлэгдсэн лабораторид даац, маркийг тодорхойлуулж, Тавантолгойн төмөр замын хяналтын инженерүүд долоо хоног бүр хоёр удаа бэлэн болсон бүтээгдэхүүнүүдийг орчин цагийн шаардлага хангасан зориулалтын багаж, тоног төхөөрөмжөөр шалган баталгаажуулж байгаа нь үйлдвэрийн бүтээгдэхүүний бат бөх чанарын бодит үзүүлэлт болжээ.

Инженер техникийн ажилтнууд зураг, төслийн дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэх аргачлал, технологийн зааварчилгаа боловсруулж, үйлдвэрийн ажилчид болох Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн зарим офицер, ахлагч нар, 017 дугаар ангийн инженер техникийн ажилтнууд, барилгачид өдрийн төлөвлөгөө нормоо 100 хувиар чанартай сайн гүйцэтгэж байгаа бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Тавантолгой-Зүүнбаян

чиглэлийн төмөр замын трассын дагуух шаардлагатай цэгүүдэд тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Эл үйл хэрэгт талбайн инженер, дэслэгч М.Алтансүх, 2019 оны ангийн "Шилдэг өсөх ирээдүйтэй залуу барилгачин"-аар шалгарсан дэд ахлагч Б.Тэмүүлэн, Л.Лхагвасүрэн, С.Сайнхүү, мөн оны тэргүүний ахлагч, дэд ахлагч Г.Энхболд, гагнуурчин, дэд ахлагч Л.Бат-Эрдэнэ, бетончин, дэд ахлагч О.Дарханбаатар, кранчин, сургагч ахлагч С.Мягмарсүрэн нар хамт олноо хошуучлан ажиллаж байгааг онцолж дурдахад таатай байна.

"Манай хамт олон эх орныхоо их бүтээн байгуулалтад өөрийн гэсэн хувь нэмрээ оруулахаар шамдаж байна. Бид энэ жил ганц энэ үйлдвэрийн ажлаар зогсохгүй шинэ төмөр замын дагуух барилга угсралтын ажлууд болон Зэвсэгт хүчний анги, салбаруудад шинээр баригдах барилга угсралт, засварын ажлуудаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байгаа. Ажлын арвин туршлага бүхий зөвлөх инженер, бэлтгэл хурандаа Т.Батбаяр зэрэг зарим ахмад инженер техникийн ажилтныг шаардлагатай ажилдаа татан оролцуулж байгаа нь үр дүнгээ өгч байна" хэмээн тус ангийн удирдлага ам сайтай байлаа.

Хийж бүтээнэ гэсэн чинхүү хүсэл, сэтгэл байхад хийж бүтээсэн ажлын чанар, үр дүн ямар болох нь ойлгогдох буюу. Усны эх цэвэр бол адаг нь тунгалаг гэдэг ...

Дэд хурандаа С.ЗОРИГБААТАР

## Хилийн чанадаас

### САР ШИНИЙН БАЯРЫГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

ИБНАУ-д явагдаж буй "Шийдвэртэй дэмжлэг" олон улсын ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XI ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүн 2020 оны 2 дугаар сарын 24-ний өдөр XVII жарны "Хотол төгс" хэмээгч төмөр хулгана жилийн Сар шинийн баярыг тэмдэглэн өнгөрүүлээ. Сар шинийн баярыг тохиолдуулан хойд бүсийн командлагч, бригадын генерал Юрген Броетз тэргүүтэй АНУ, ХБНГУ, Хорват, Афганистан зэрэг улсын цэргийн төлөөлөл хүрэлцэн ирж Монголын уламжлалт баяр, зан үйлтэй танилцан бие бүрэлдэхүүнд мэндчилгээ дэвшүүлээ. Энэ хүрээнд сумын

цолтой болон залуу бөхчүүд оролцсон 32 бөхийн барилдаан зохион байгуулагдаж, ахмад Б.Банзрагч (Зэвсэгт хүчний 150 дугаар анги) түрүүлж, ахлах ахлагч С.Батмөнх (Зэвсэгт хүчний 123 дугаар анги) үзүүлж хурсан олныг баясгалаа.

Мөн Цэргийн багийн захирагчийн санаачилгаар ахлах дэслэгч Д.Мөнхтулга захирагчтай бүрэлдэхүүн "Их өргөө" төслийг сар шинийн баярын босгон дээр хэрэгжүүлж дуусгаснаар монгол гэрийг байрлуулан гадаадын цэргийн алба хаагчдад олон зууны түүхтэй монгол ахуй, амьдралыг сурталчлан таниулах томоохон арга хэмжээг зохион байгууллаа.

### "STRONG MAN" ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОВ

Нидерланд улсын Цэргийн багаас зохион байгуулсан "МАРМАЛ" баазын аварга шалгаруулах "STRONG MAN" тэмцээнд Монгол, АНУ, ХБНГУ, Хорват, Гүрж, Бельгийн вант улс зэрэг эвслийн цэргийн баг тамирчид оролцон хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт Бельги, дэд байрт Монгол, гуравдугаар байрт АНУ, тусгай байрт ХБНГУ-ын цэргийн багийн баг тамирчид тус тус шалгарлаа.

Хошууч Д.ХАШХҮҮ



## Редакцын шууданд

### 110 дугаар анги

Орхон аймгийн Говил багийн "Эгшиглэн" соёлын төв, номын сантай хамтран "Ухаан далай номоос эхтэй" нэг сарын аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд бие бүрэлдэхүүний дунд уран зохиолын номын нэр, зохиогчийг таах тэмцээнийг явууллаа. Мөн хамгийн их ном уншсан цэргийн алба хаагч, ажилтнаар дэд ахлагч Д.Бат-Амар, Э.Азжаргалбаяр, номын санч Ц.Хоролсүрэн нар шалгарлаа.

Дэслэгч Д.ДАВААЖАРГАЛ

### "Бөртэ" ТӨААТҮГ

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Бөртэ" ТӨААТҮГ-ын ажилтан албан хаагчид БХА-нд 200, ЗХЖШ-т 3300, ҮХБИС-д 300 маскийг оёж хандивлав.

## ТАВАН МЯНГАН ШИРХЭГ АМНЫ ХААЛТ БЭЛЭГЛЭВ

"Алдар" спорт хорооны дарга, хурандаа Г.Өсөхбаяр Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд 5000 ширхэг амны хаалтыг ил захидлын хамт өглөө. Тэрбээр захидалдаа "Аюулт хөндийн гараад нэлээд хугацаа өнгөрлөө. Өнөөдөр дэлхийн 50 улсад аюулын харанга дэлдэж буй энэ үед манай улсын Засгийн газар, ялангуяа эрүүл мэндийн салбар бүхлээрээ монголчууд бидний эрүүл мэндийг сахин хамгаалах ариун үүргээ нэр төртэй гүйцэтгэж байна. Ийм үед иргэн бүр хариуцлагатай байж, мөн өөрийн боломж бүхнээр аюулт тахлаас урьдчилан сэргийлэхэд оролцох ёстой гэж би бодож байна. Тиймээс өнөөдөр гэрийн бүлийнхээ өмнөөс монголчууддаа эрүүл энхийг хүсэж, 5000 ширхэг амны хаалтыг хэрэгцээтэй газар нь хүргэж өгөхийг хүслээ. Монголчууд бид бие биеэ хайрлах, хууль цаазаа чанд сахин эх орон, ард түмнээ хайрлах ухамсарт ард түмэн гэдэгт би итгэдэг.



Энэ дашрамд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдад бидний төлөө цаг наргүй ажиллаж байгаад иргэн хүнийг хувьд талархаж буйгаа илэрхийлж байна" гэжээ.

## БИД ТАНГАРАГ НЭГТЭЙ АЛБА ХААГЧИД

Дэлхий нийтэд тархаад буй шинэ төрлийн коронавирусийн тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, нийслэлийн орох, гарах замуудыг баярын өдрүүдэд хаасан. Баянхонгор аймгийн хувьд аймгийн онцгой комиссын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөл хорио тогтоохын зэрэгцээ аймгийн төв тойрсон 15 постод цагдаа, онцгой, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, тээврийн хяналтын газрын 78 албан хаагч 24 цагаар ажилласан юм. Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн алба хаагчид 2 дугаар сарын 25-ны өдөр уг постуудад үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад халуун хоол, аарцаар үйлчилжээ.

Зэвсэгт хүчний 330 дугаар анги "COVID-19" вирусээс урьдчилан сэргийлэх зорилготойгоор Дархан-Уул аймгийн хэмжээнд үүрэг гүйцэтгэж буй Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн



хяналт, эрүүл мэндийн байгууллагуудаас томилогдсон зургаан шалган нэвтрүүлэх цэгт ажиллаж байгаа 41 төрийн алба хаагчдад халуун хоол, цайгаар үйлчилж дэмжлэг үзүүлээ.

## ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ЭСРЭГ ЭМЭГТЭЙЧҮҮД ...



Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн бүрэлдэхүүн 2019-2020 оны сургуулийн жилийн нэгдүгээр үеийн хээрийн гаралт, полигоны дадлагыг Хуурай замын цэргийн командлалын сургалтын төв, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн байрлалд явууллаа.

Мөн "COVID-19" вирусийн тархалтаас

урьдчилан сэргийлэх зорилгоор ангийн мэдээллийн самбар, цахим хуудсанд өвчний талаарх сүүлийн үеийн мэдээллүүдийг байршуулан эмэгтэй цэргийн алба хаагч, ажилтнууд 600 ширхэг амны хаалт оёж, бие бүрэлдэхүүн, тэдний гэр бүлд хандивлалаа.

Ахмад Б.БУРМАА

ТЭДНИЙ ТУХАЙ

Зэвсэгт хүчний хөгжилд хамгийн чухал зүйл нь юу вэ гэсэн асуултад уншигч та хамгийн түрүүнд мэргэшсэн боловсон хүчин, зэвсэглэл, техникийн сайжруулалт гэж хариулах байх. Энэ нь ч үнэн. Гэхдээ үүнээс гадна бас нэгэн чухал хүчин зүйл нь цэргийн алба хаагчид, албан тушаалтнуудын ая тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлсэн барилга байгууламж бөгөөд түүний ашиглалтыг сайжруулахад чиглэгдсэн асуудал юм. Өнөө үед Зэвсэгт хүчний хөгжлийн хурд жилээс жилд нэмэгдэж байгаатай уялдаад бүтээн байгуулалтын ажил ихээр хийгдэх болсон. Тэгвэл өнөөдөр Зэвсэгт хүчний уг хэрэгцээ, шаардлагыг хангаж, гол ажлыг нь нугалж байгаа байгууллага нь Батлан хамгаалах яамны "Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ юм.

1922 онд Ардын Засгийн газраас гэр агуулах, агтны саравч засах цэргийн хуаран байгуулж, засаж сэлбэх зэрэг ажилд зохих хөрөнгө олгох шийдвэр гаргажээ.

стандарт, гэрчилгээг шалгах, суурийн нүх ухахад хөрсний бүтэц геологийн судалгаатай тохирч байгаа эсэхэд хяналт тавьдаг. Мөн суурийн, зоорины давхрын арматурчлал, бетоны ажил, "0.00" түвшин, тэнхлэг хооронд шалгах, давтагдах давхрын бетон хийц, өрлөг, шатны арматурчлал, агааржуулалтын сувгийн ажил, хаалга, цонх, шал, гадна, дотор заслын ажил, гадна ханын дулаалга, дулаан, цэвэр, бохир ус, цахилгааны ажил, дотор сантехник, дээвэр, баримт бичгийн шалгалт, барилга угсралт зураг, төслийн дагуу хийгдсэн эсэх гээд бүгдийг нэг бүрчлэн хянаж шалгана. Түүнчлэн улсын комиссыг ажиллуулж, тухайн барилгыг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөхөд шат дараалсан бусад ажлыг хийж гүйцэтгэх зэрэг олон төрлийн хяналтыг мэргэжлийн өндөр түвшинд хийдэг байгууллага ажээ.

Мөн дан ганц барилгын ажилд хяналт тавиад зогсохгүй алба хаагчдын эрүүл мэнд, сэтгэл зүйн түвшнийг дээшлүүлэх



Өвөр эгнээнд баруун гар талаас: Нягтлан бодогч, ахмад А.ДОРЖ, дарга Э.МӨНХНАРАН, хяналтын инженер, ахмад О.ЭРДЭНЭБУЛГАН, арын эгнээнд баруун гар талаас: Аж ахуйн нярав Э.МӨНХТҮШИГ, хяналтын инженер, дэслэгч Б.ГАН-ЭРДЭНЭ, нууц, архив, бичиг хэргийн ажилтан Г.ПҮРЭВДОЛГОР, хяналтын инженер, ахлах дэслэгч Д.ДОРЖХАНД, жолооч Д.ЛХАГВАДОРЖ

# ХЯНАЛТ БОЛ ТЭДНИЙ ГОЛ АЖИЛ

Ингээд барилгын мэргэжлийн дээд боловсролтой хүмүүсийг энэхүү ажилд авч ажиллуулахыг Бүх цэргийн яаманд зөвшөөрснөөр одоогийн Барилга захиалагчийн албаны түүхийн хуудас эхэлсэн ажээ.

"Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь барилга, нийтийн аж ахуйн талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан улсын төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралт болох "Барилгын аюулын захиалагчийн дүрэм" болон барилгын норм, дүрэм, журам, бусад хуулийн хүрээнд барилгын үйл ажиллагааг эрхлэн явуулахад чиглэгддэг аж. Тус байгууллагын дарга Э.Мөнхнаран хэлэхдээ "Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулан төсвийн жишиг үнэлгээ, үнийн индекс, стандартад хяналт тавих, инженер, техникийн ажилтнуудаа сургалтад хамруулах, салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулах зэрэг үндсэн чиг үүргийн хүрээнд мэргэжлийн чадварлаг хамт олноор багаа бүрдүүлэн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журмууд, барилгын норм, дүрэм, стандартыг мөрдүүлэн, материалын чанар байдалд анхаарч, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах зорилго, зорилтуудыг тавин үйл ажиллагаагаа жилээс жилд өргөжүүлэн ажиллаж байна" гэсэн.

Тухайн байгууллагын гол хяналт бол барилга, байгууламжийн чанар, стандартыг алдагдуулахгүй байхад чиглэгддэг. Иймдээ ч барилгын үе шат болон материалын чанарт судалгаа хийж, лабораторийн дүгнэлт гаргуулан чанарын шаардлага хангасан материалаар барилгын үйлдвэрлэлийг явуулахад хяналт тавин ажиллаж байна. Мэдээж хяналтыг бүх түвшинд, өндөр үр дүнтэй зохион байгуулснаар тухайн барилга нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлагыг хангана шүү дээ. Иймээс тэд олон төрлийн хяналтыг явуулдаг онцлогтой. Тэдгээрээс дурдвал, орон нутаг болон яам, агентлагаас ирсэн саналыг үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалт, бусад төсөл, хөтөлбөрүүд, гадаад, дотоодын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавина. Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн инженерийн барилга байгууламжид технологийн туршилт, тохируулга хийлгэж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг. Зураг, төсвийг хийх, хүлээн авах, шалгах, барилгын улаан шугам, тэг тэнхлэг татах, барилга угсралтад ашиглах материал, тоног төхөөрөмжийн чанар, эдлэлийн

талаар анхаарч, хэд хэдэн ажил санаачлан жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг байна. Жендерийн тэгш байдлыг хангах, хүүхдийн хүчирхийллийг бууруулах нь манай нийгмийн гол асуудлуудын нэг болоод байгаа. Үүнд тус хамт олон өөрсдийн хувь нэмрээ оруулж, тодорхой үр дүнд хүрч ажиллаж байгаа гэнэ. Энэ тухай Э.Мөнхнаран "Манай байгууллага нь сэтгэл судлал, гэр бүлийн харилцаа, хандлагын талаар, "Нийгмийн эрүүл мэнд хүний хөгжлийн институт" ТББ-тай жил бүр хамтран алба хаагчдаа сургалт явуулдаг. Байгууллагын ажилтнуудаар дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, тэднийг хамгаалахад эцэг, эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхийг уриалан сурталчлах зорилготойгоор гэр бүлийн бүх гишүүдийг хамруулсан аялал, арга хэмжээг зохион байгуулж хэвшсэн. Ингэснээр хамт олонч уур амьсгал бүрдэж, хүн нэг бүрийн багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. Мөн жил бүр хамт олноороо жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд олон нийтийг уриалах, мэдээллийн самбар болон нүүр хуудсаар дамжуулан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж ирлээ" гэсэн юм.

Мөн спортоор дамжуулан хамт олны идэвх, санаачилгыг нэмэгдүүлэхийг зорьдог байна. Нягтлан бодогч, ахмад А.Дорж хэлэхдээ "Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг бүх нийтийн хүртээл болгох, БХЯ, ЗХЖШ, бусад харьяа байгууллагын бие бүрэлдэхүүний дунд бие бялдар, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор спортын нөхөрсөг цогцолбор тэмцээнийг 2017, 2018 онд зохион байгуулсан бол 2019 онд дээрх тэмцээнийг Цэргийн төв эмнэлэгтэй хамтран өргөн хүрээнд амжилттай явуулсан юм. Түүнчлэн байгууллагын удирдлагаас албан тушаалтнуудыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулж, ажиллах нөхцөл бололцоогоор нь бүрэн хангаж, шаардлагатай бүхий л тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангадаг гэдгийг энд тэмдэглэн хэлэхэд таатай байна" гэлээ.

"Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ-ын Батлан хамгаалахын эрх зүйн орчныг шинэчлэх, улс орны батлан хамгаалах чадавх, аюулгүй байдлын баталгааг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлэн 2017, 2019 оны Батлан хамгаалах яамны "Оны тэргүүний

байгууллага"-аар шалгаруулсныг энд онцлох учиртай. Энэ бол тус байгууллагын хамт олны нөр их хөдөлмөрийг үнэлсэн бодит жишээ юм. Мөн Батлан хамгаалахын Төв архиваас явуулсан архив, албан хэрэг хөтлөлт, баримтын хадгалалт, хамгаалалтын байдалд явуулсан үзлэгт "А" үнэлгээтэй шалгагдсан зэрэг ололт амжилтаар дүүрэн өнгөрсөн оноо үджээ.

Мөн гадаад харилцаанд ч ахиц, дэвшил гарсан байна. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газраас баталсан "Барилгын салбарт төрөөс баримтлах бодлого" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд барилга, бүтээн байгуулалтын салбарын бодлогыг тодорхойлогч 150 гаруй бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэгтгэсэн "Монголын Барилгын Үндэсний Ассоциаци"-ийн гишүүн болж хамтын харилцаагаа өргөжүүлжээ. Энэ тухай Э.Мөнхнаран хэлэхдээ "Бид "Монголын Барилгын Үндэсний Ассоциаци"-ийн гишүүн болсноор Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй томоохон хөрөнгө оруулагч, хөгжүүлэгч, барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэгч, зураг, төслийн чиглэлийн 150 гаруй гишүүн байгууллагатай хамтран ажиллах, барилгын салбарт сайн засаглалыг бий болгоход төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдааг сайжруулж, хууль, эрх зүйн орчинд шинэчлэл хийхэд нөлөөлөх, барилгын материалын үйлдвэрлэл, техник, технологи, санхүү, эдийн засаг, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл, орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, гадаадын бизнес эрхлэгчдийн санал, холбогдох хууль тогтоомж болон бусад мэдээллийг цаг тухайд нь авах, хууль, эрх зүй, олон улсын байгууллага, компаниудтай үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны харилцаа, холбоог тогтооход дэмжлэг авах, ассоциацийн шугамаар төсөл, хөтөлбөрт холбогдох боломжийн тухай мэдээлэл авах, төслөө хөрөнгө оруулагчдад танилцуулах, гадаад орнуудад зохион байгуулагдах барилгын үзэсгэлэн яармагт оролцох, танилцах аялал, техникийн семинарт хамрагдах зэрэг маш олон боломж бидэнд шинээр нээгдлээ" гэсэн.

Энэ онд тус байгууллагад хийхээр төлөвлөсөн нэлээд ажил байгаа ажээ. Тэр дундаа Зэвсэгт хүчний Ар талын газрын Орон сууцны хэлтэс, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн Зураг төслийн тасагтай хамтран барилга угсралтын ажлуудыг эхлүүлэхэд шаардагдах техникийн баримт бичгүүдийг зохих журмын дагуу гүйцэтгэх их ажилд ханцуй шамлан оржээ. Эцэст нь Э.Мөнхнаран "Биднийг дэмжин ажилладаг БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, төрийн

байгууллагууд болон Барилгын цэргийн ангиуд, байгууллага, хувь хүмүүс, бизнесийн түншүүддээ

талархал илэрхийлэн 2020 ондоо амжилт бүтээлээр дүүрэн байхыг хүсэн ерөөе" гэсэн юм.

## "БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЛБА" ТӨААТҮГ-ЫН ХИЙСЭН ЗАРИМ ТОМООХОН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУДААС ...



Хуурай замын цэргийн командлалын шинэ байр



Батлан хамгаалах яамны дэргэдэх 120 хүүхдийн "Цоглог" цэцэрлэгийн байр



ҮБХИС-ийн олон улсын хурлын заал



Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд байрлах "Аравт" олон улсын морин цэргийн уралдаанд зориулсан саадын зурвас

## ДУГААРЫН СУРВАЛЖИЛГА

Дэлхий нийтэд шинэ төрлийн коронавирус буюу "COVID-19"-ийн халдвар эрчимжсэнээр аливаа улс орнууд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тархалттай тэмцэх чиглэлээр дор бүрнээ хичээж, шаардлагатай бүхнийг хийж байгааг уншигч та надаар хэлүүлэлтгүй мэднэ. Харин түгшүүрт энэ цаг үеийг эрсдэл багатай туулахад Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн бие бүрэлдэхүүн зохих хувь нэмрээ оруулж байгааг тэмдэглэх нь зүйн хэрэг юм. Тус лабораторийн хамт олон Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийсээр сар гаруйн нүүрийг үзэж байна. Энэ талаар Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн дарга, улсын байцаагч, хошууч У.Ганзам "Шинэ төрлийн коронавирус буюу "COVID-19"-ийн тархалттай холбогдуулан урьдчилан сэргийлэх чиглэлээр ЗХЖШ-аас албан даалгавар, зөвлөмжүүд гарч байна. Батлан хамгаалах яам, ЗХЖШ, ХЗЦК, АЦК, АТГ-уудад долоо хоногт нэг удаа бүх өрөө, тасалгаанд ариутгал, халдваргүйтгэлийг хийдэг. Нийтдээ 20 гаруй мянган м<sup>2</sup> талбайд ариутгал хийгээд байна. Жавелиний уусмал одоохондоо хүрэлцээтэй байгаа ч цаашид нөөц хомсдож болзошгүй" гэв.

Түүх сөхвөөс, ЗХЖШ-ын даргын 2002 оны тушаалаар Хэмжил зүй, Хими, Мал эмнэлгийн бактери шинжилгээ, Шатахууны, Эрүүл зүйн бичил амь судлал-химийн лабораториудыг нэгтгэн Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори болгон ХШУГ-ын мэргэжлийн удирдлагад шилжүүлсэн байдаг. Тэр цагаас хойш Зэвсэгт хүчинд хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулах, хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулга, баталгаажуулалт, шатахуун, тос тосолгооны материал, тусгай шингэн, хүнс, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн, химийн хортой болон тусгай цэвэрлэгээний бодис, урвалжийн чанар байдлыг тодорхойлох, мал, амьтан д мал эмнэлгийн үзлэг, оношилгоо, сорилт шинжилгээний ажил үйлчилгээг үзүүлсээр иржээ. Ингээд зогсохгүй байгалийн гамшиг, үйлдвэрийн ослын үед эрүүл ахуй, мал эмнэлэг, цацраг, химийн лабораторийн үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлдэг онцлогтой аж.

Тус хамт олон 2019 онд "Үндсэн үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийг тасралтгүй зохион байгуулах, Сорилтын болон шалгалт тохируулгын лабораториудад тавигдах ерөнхий шаардлагыг олон улсын стандартад нийцүүлэх бэлтгэл ажлыг хангах, ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах" зорилгыг дэвшүүлэн ажиллажээ. Үүний хүрээнд цэргийн сургалт бэлтгэлийг Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлогтой уялдуулан чанартай, тасралтгүй зохион байгуулж, сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэх, "Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийг 2020-2030 он хүртэл хөгжүүлэх дунд шатны хөтөлбөр"-ийг боловсруулж, хэрэгжүүлэх, албан тушаалтнуудыг ажлын байранд нь мэргэшүүлэх, дэвшилтэт технологи, стандартыг судлах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн байна. Лабораторийнхан төлөвлөгөөний биелэлтээ бүрэн дүүрэн ханган ажилласны хамгийн тод илрэл нь дээрх зорилтуудын нэг "Зэвсэгт хүчний

Нэгдсэн лабораторийг 2020-2030 он хүртэл хөгжүүлэх дунд шатны хөтөлбөр"-ийг түүхэндээ анх удаа боловсруулсан бөгөөд Батлан хамгаалахын сайдын зөвлөл болон ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, бие бүрэлдэхүүн толгой өндийх завгүй их ажилтай золгоод байна.

Хөтөлбөр хэрэгжсэнээр Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори нь орчин үеийн

дунд хугацааны хөтөлбөрөө батлуулснаар тоног төхөөрөмж, багаж хэрэгслээ шинэчлэн олон жил болсон толгойны өвчнөөсөө салах мөч тун ойртсоор байна.

Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори нь бүтцийн таван лабораторитой бөгөөд тэдгээр нь өөр өөрийн гэсэн онцлогтой. Жишээлбэл, Мал эмнэлгийн бактери шинжилгээний лаборатори нь 1972 онд Хүн, мал эмнэлгийн нэгдсэн лаборатори нэртэйгээр

хийж үүрэг гүйцэтгэдэг байсан, өдгөө өргөн бүрэлдэхүүнтэй, өнөр хамт олонтой болсон гээд нэлээд зүйлийг хуучилсан бөгөөд "Хүн өссөн орчиндоо их дасдаг юм шиг. Жишээлбэл, эмчийн хүүхэд эмч болдог бол малчны хүүхэд малчин болдог. Гэхдээ сайн эмч, сайн малчнаас илүү үр, хүүхдүүдээ үлгэр дуурайл болсон аав, ээж байх нь хүн ёсны чухал асуудал юм" гэхэд ёстой л загатнасан газар маажих шиг болж, залуу үеэ

тасалгааны агаар, хүнс, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнд нян судлалын болон химийн шинжилгээг хийдэг. Түүнчлэн жилд дунджаар хортон мэрэгч устгалыг зохих талбайд, хүнс үйлчилгээнд ажиллагсдад урьдчилан сэргийлэх шинжилгээг хийсээр иржээ. Өнгөрсөн оны тухайд "Хааны эрэлд-2019" олон улсын хамтарсан хэргийн сургуульд тус лабораторийн дарга, ахмад З.Эрхэмбаяр, хэргийн автолабораторийн

# ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮҮД БОЛСОН ЛАБОРАТОРИ



Хошууч У.ГАНЗАМ

өндөр нарийвчлалтай эталон, тоног төхөөрөмжөөр хангагдан, сорилт шинжилгээний ажлыг стандартын дагуу бүрэн үзүүлэлтээр хийснээр анги, салбарын зэвсэглэл, техникийн бэлэн байдал, цэргийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хангагдаж, шалгалт, тохируулга, баталгаажуулалт, сорилт шинжилгээний итгэмжлэлийн хүрээ нэмэгдэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй тэргүүлэх лабораториудын жишигт хүрэх боломжтой аж. Үнэхээр ч одоо ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийн 80-90 хувь нь ЗХУ-д 1970-1980 онд үйлдвэрлэгдсэн бөгөөд манайд нутагшаад 40 гаруй жилийн нүүрийг үзсэн учир хуучирч насжилт өндөр болсноос үүрэг гүйцэтгэх боломж нь хумигдсаар байгаа аж. Энэ мэт техникийн хоцрогдлоос шалтгаалан нэгж шинжилгээнд зарцуулах хугацаа ихсэхийн зэрэгцээ сорилт шинжилгээг хийхэд хүндрэлтэй байдал үүсдэг байна.

Нэг зүйлийг онцлоход Стандарт, хэмжил зүйн газрын итгэмжлэлийн хэлтсээс баталдаг "Сорилтын болон шалгалт, тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/ IEC 17025:2007 стандартын дагуу тус лаборатори 2-4 жилийн хугацаатай итгэмжлэлийн эрхээ сунгуулан үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн. Энэ удаад итгэмжлэлийн эрхээ сунгуулах ажлыг зохион байгуулах хүрээнд ч Стандарт, хэмжил зүйн газраас заагдсан үл тохирлыг арилгаж, итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх хүчин чадал бүхий багаж, тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийг шинээр худалдан авах шаардлага бий аж. Ийнхүү зэрэг тохироо бүрдсэн энэ цаг дор тус лабораторийн хамт олон

байгуулагдсан бөгөөд Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний мэдлийн туслах аж ахуйн мал, амьтанд урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд нян судлал, ариун цэврийн шинжилгээ хийж, мах, махан бүтээгдэхүүнд хяналт тавин ажилладаг. Мөн сэжигтэй тохиолдол илэрсэн бол тус лабораторид дээжийг нь шинжлэхээс гадна өөрсдөө ч малын суурь дээр очиж тогтмол тандалтын шинжилгээ хийж оношлон аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулдаг аж. Товчхондоо Зэвсэгт хүчний ангиудад хэрэглэгдэж байгаа хүнсний болон мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн асуудалд гол анхаарлаа хандуулдаг гэхэд болно. Түүнчлэн бид төдийлөн сайн мэддэггүй нэг зүйл нь "Олон улсын цэргийн наадам-2019"-ийн хүрээнд зохион байгуулагдсан "Аравт" морин цэргийн уралдааныг зохион байгуулах ажилд тус лабораторийн бие бүрэлдэхүүн гар бие оролцож оногдсон үүргээ алдаа мадаггүй гүйцэтгэсэн байна. Ахлах дэслэгч М.Энхтайваны хувьд Зэвсэгт хүчний 232 дугаар ангид найман жил алба хаагаад энэхүү лабораторийн даргаар томилогдоод нэг их удаагүй ч хамт олныхоо дунд хурдан "идээшсэн"-ээс гадна цэргээсээ дарга хүртэлх хэн бүхний зөвлөгөөг ажил хэрэг болгодог гэж ахмад ажилтнууд онцолж байв. Тэрээр малын заххаас холдолгүй байсаар оюутан болохдоо хүний их эмчийн хуваарь байсан ч малын их эмчийн мэргэжлийг сонгосон байна. Түүний аав ч удам дамжсан малын эмч аж. Нутаг орондоо очиж ажиллахыг хүссэн ч түүнээс илүүтэй төрийн торгон сүрэгтэй ангид малын их эмчээр ажиллах завшаан олдсонд олзуурхаж боломжийг тас зуураад авсан нь өнөөдрийн Мал эмнэлгийн бактери шинжилгээний лабораторийн дарга болох замын эхлэл байсан гэлтэй.

Лаборант Б.Жаргал энэхүү лабораторид 21 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд залуу үеэ мэргэшүүлэх, ажил мэргэжилд нь дурлуулахад ихээхэн анхаардаг. Ингэснээр тэрээр гавьяаныхаа амралтад гарсан ч өөр хэн нэгэн залгамж халааг нь авч, хөдөлмөр үйлсийг нь үргэлжлүүлэх учраас сэтгэл эргэж уягдаад байх зүйлгүй биз ээ. Түүний нэг өдрийн ажлыг сонирхуулахад, өглөө дарга нарын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу ажиллах бөгөөд сорилт, шинжилгээ хийгдэх бол голлох үүргийн нь хүлээж электрон жингийнхээ зөв, буруу зааж байгаа эсэхийг хамгийн түрүүнд нягталж, тэмдэглээ хөтөлдөг. Үргэлжлүүлэн дээжээ жинлэх зэргээр түүний гараар дамжихгүй үйл явц тун ховор. Мөн тэрээр Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн үүсэл хөгжлийн талаар буюу анх ямар байшинд, хэрхэн шинжилгээ, оношилгоо

чадваржуулахаас гадна хүн байх ухаанд сургадаг болов уу гэсэн бодол төрснийг нуух юун.

Дараагийнх нь Хэмжил зүйн лаборатори. Анх 1983 онд Ардын Армийн 137 дугаар төв лаборатори нэртэйгээр байгуулагдаж байсан. Эзлэхүүн багтаамж, шугаман өнцгийн хэмжүүрийн болон механик даралтын хэмжүүр, радио техник, цахилгаан хэмжүүрийн гэсэн гурван тасагтай. Гүйцэтгэх үүргийн хувьд, Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчинд ашиглагдаж, хадгалагдаж байгаа зэвсэг, техник хэрэгслүүдэд хэмжилт, шалгалт, тохируулга, баталгаажуулалтын ажлыг хийдэг бөгөөд жилд дунджаар хэмжлийн зургаан төрлөөр цахилгааны 1336, газардуулгын 360, аянга зайлуулагчийн 520 хэмжих хэрэгсэлд шалгалт, тохируулга, баталгаажуулалт хийдэг аж. Хэмжил зүйн хэрэгслүүдээ тухай бүрт нь Стандарт, хэмжил зүйн газарт өгч баталгаажуулдаг учраас хэмжилт ямар ч үед үнэн зөв хийгддэг. Мөн хөдөө, орон нутгийн болон Улаанбаатар цэргийн хүрээний бүх ангиудад хүрч ажиллагдгаараа онцлогтой. Тус лабораторийн эзлэхүүний хэмжүүрийн тохируулагч, засварчин, ахлагч Б.Энхбаяр Зэвсэгт хүчинд 21 дэх жилдээ алба хааж буй. Энэ хугацаанд хилийн чанадад гурван удаа үүрэг гүйцэтгэсэн туршлагатай. Түүнчлэн өөрийн туршлага, сурсан мэдсэнээ бусадтай харамгүй хуваалцаж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд хүүгийнхээ сургуульд цэрэг-эх оронч үзлийн талаар хэд хэдэн удаагийн лекц уншсан нь түүнийг ямар ч үед Зэвсэгт хүчинтэйгээ зүрх сэтгэлээрээ ойр байдаг гэдгийг бэлхнээ харуулах биз.

Харин Цэргийн химийн лабораторийн хувьд хөдөлгөөнт болон суурин хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг. Үндсэн үүргийн хувьд Зэвсэгт хүчний анги, салбаруудад ашиглагдаж, хадгалагдаж байгаа тусгай идэвхт үүсгүүрийн хадгалалт, хамгаалалт, чанар байдлыг тодорхойлж, хяналт тавихын сацуу түүнтэй харьцагсдад аюулгүйн зааварчилгаа өгч ажилладаг аж. Харин хөдөлгөөнт лаборатори гамшигын үед дэмжлэг үзүүлэх бүлэгтэй, хэргийн ямар ч нөхцөлд үүрэг гүйцэтгэх боломжтой бөгөөд жилд нэг удаа зохиогддог химийн нэгдсэн дадлага сургуулилтад бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцдог байна.

Анх 1973 онд "Армийн ариун цэвэр, халдвар судлалын групп"-ийн дэргэд байгуулагдсан Эрүүл зүй, бичил амь судлал-химийн лаборатори нь Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын үдийн хоолны илчлэгийг тодорхойлох, ундны ус, ариун цэврийн арчдас,

дарга, ахлах лаборант, дэд ахлагч Б.Болорчимэг, жолооч ахлагч Г.Батзориг нар хөдөлгөөнт хэргийн лабораторитой оролцож, үүрэг гүйцэтгэсэн бол Монгол Улсын нутаг дэвсгэрийг дайран өнгөрсөн "Авторалли-2019" тэмцээнд мөн л ахмад З.Эрхэмбаяр эрүүл ахуйч эмчээр 14 өдрийн томиллолтоор ажилласан нь мэдлэг, ур чадвараа ахиулан бусад орны Зэвсэгт хүчний алба хаагчдаас туршлага хуримтлуулсан шинэлэг, ач холбогдолтой зүйл болсон гээд лабораторийн удирдлагууд ихэд сэтгэл хангалуун байдаг юм билээ.

Хамгийн сүүлд буюу 1982 онд байгуулагдсан Шатахууны лабораторийн талаар өгүүлье. Үндсэн үүрэг нь Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчин, гэрээт аж ахуйн нэгж, байгууллагын автобензин, тос, тосолгооны материал, тусгай шингэн, дизель түлшний дээжид хяналтын болон иж бүрэн шинжилгээ хийх, тэдгээрийн төрөл, хадгалалтын хугацааг тогтоож тоон болон чанарын хяналт тавьж ажиллахад чиглэгдэнэ. Үүний зэрэгцээ зарим аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагаатай. Тухайлбал, "Тэс Петролиум", "Магнай Трэйд" ХХК зэрэг аж ахуйн нэгжийн шатахуунд тогтмол сорьц, шинжилгээ хийдэг нь Зэвсэгт хүчнээ сурталчлах, нэр хүндийг нь өргөхөд чухал нөлөө үзүүлдэг гэнэ.

Бусад ажлын талаар Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн дарга, улсын байцаагч, хошууч У.Ганзам хэлэхдээ "Тус лаборатори нь зориулалтын бус байранд байдаг хэдий ч өөрсдийн нөөц бололцоогоороо засвар, үйлчилгээ хийж, зургаан автомашины дулаан гражийг барин ашиглаж байна. Үүнээс гадна зарим төрлийн хүнсний ногоог тариалан, туслах аж ахуйтай болсон, лабораторидоо ажилчдын гал тогоог шинээр тохижуулж, нэг хоолыг 2000 төгрөгөөр худалдаалдаг зэрэг бие бүрэлдэхүүнийхээ нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бодитой дэмжлэг үзүүлэх ажлууд бага багаар хийгдэж байна. Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд 0-5 насны хүүхэдтэй ажилтнуудынхаа судалгааг гаргаж, биеийн байдлыг нь харгалзан үзээд тав хүртэлх хоногийн чөлөөг нь олгосон. Эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээнд тогтмол бүрэн хамруулж, энхийг дэмжих ажиллагаанд алба хаагчдаа оролцуулахад анхаарч, санаа тавьж ажилладаг. Мөн боловсон хүчнээ мэргэшүүлэх талаар анхаарч жил бүр алба хаагч, ажилтнуудаа сургалт, хурал, зөвлөгөөнд идэвхтэй хамруулж хооронд нь туршлага солилцуулан ур чадварыг нь ахиулах талаар нэлээд ажлын ард бид гарсан" гэв. Зэвсэгт хүчний нүд болсон лабораторийн талаар товч өгүүлэхэд ийм буюу.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ



Бодисын чанарын байдлын шинжилгээ хийгдэж байна

# ХОЁРДУГААР САРЫН ТЭРГҮҮНҮҮДЭЭ ТОДРУУЛЛАА

БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн сар бүр хийж бүтээсэн ажлаа хэлэлцэн тайлагнаж, хамт олноо үлгэрлэн манлайлсан цэргийн алба хаагчдаа шалгаруулан урамшуулдаг уламжлалтай. Энэ жишгээр тус батальоны бие бүрэлдэхүүн 2 дугаар сарын тэргүүнүүдээ шалгарууллаа.

Тодруулбал, "Сарын тэргүүний штабын офицер"-оор ахмад Д.Эрдэнэ-Очир (330), "Сарын тэргүүний салбарын офицер"-оор дэслэгч Б.Дугаржав (337), "Сарын тэргүүний ахлагч"-аар сургагч ахлагч Б.Сэргэлэн (338), ахлах ахлагч Г.Эрдэнэбаатар (256), дэд ахлагч Д.Лхагвадорж (017) нар шалгарлаа.

Түүнчлэн "Сарын тэргүүний авьяаслаг цэргийн алба хаагч"-аар



дэслэгч Э.Мэндбаяр (123), "Сарын тэргүүний спортоор манлайлагч цэргийн алба хаагч"-аар ахлах ахлагч Ц.Мөнх-Эрдэнэ (ҮБХИС), "Сарын тэргүүний шинийг санаачлагч, бүтээлч цэргийн алба хаагч"-аар дэд ахлагч Д.Очирбат

(065), "Сарын тэргүүний эмэгтэй цэргийн алба хаагч"-аар ахлах дэслэгч А.Довчмаа (017), "Сарын тэргүүний салаа"-гаар ахлах ахлагч Д.Орлом захирагчтай салаа тус тус шалгарч хамт олноо манлайлав.

# ХҮЧИТ 32 БӨХ ЗОДОГЛОВ



XVII жарны "Хотол төгс" хэмээх төмөр хулгана жилийн Сар шинийн барилдаанд аймаг, сумын цолтой хүчит 32 бөх зодоглосон бөгөөд 2 мбр-ын ахлах ахлагч, сумын заан Ц.Мөнх-Эрдэнэ /ҮБХИС/ түрүүлж, ХТР-ын дэд ахлагч, аймгийн начин Т.Баярсайхан /016/ үзүүлэн, 1 мбр-ын ахлагч Б.Алтангэрэл, 3 мбр-ын дэд ахлагч Д.Еркебулан нар шөвгөрлөө.

# "ЦЭНХЭР ДУУЛГАТАН"-УУД МАНЛАЙЛЖ, "БАРУУН МОНГОЛ"-ЧУУД УДААЛАВ

Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр" тэмцээн өнөө жил БНӨСУ-д зохион байгуулагдлаа. Монгол түмний үндэсний өв соёл, зан заншил, ёс уламжлал, дуу хуур, тоглоом наадаг, түүх шастир, утга зохиол, бичиг, соёлын өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, үндэсний соёл урлагийг сурталчлан тэдгээрээ дэлхийн соёлын ололттой нийцүүлэн хөгжүүлэх зэрэг олон зорилгыг агуулдаг тус тэмцээн дэлхий нийтийг цочроогоод буй цар тахлын уршгаар өнөө жил өнжихөөр байсныг ийнхүү анги, байгууллага төлөөлөн БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж буй цэнхэр дуулгатнуудын дунд зохион байгуулж, түүхийн хуудсаа нэгэн шинэ агуулгаар баяжуулсан нь энэ.

18 дахь хавартайгаа учран золгосон "Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр" тэмцээнд энэ жил Зэвсэгт хүчний 19 анги, байгууллагын баг оролцож, авхаалж самбаа, авьяас билгээ сорин өрсөлдсөн юм. Даалгавар тус бүр дээр хүчтэй бөгөөд эн тэнцүүхэн өрсөлдсөн тэдгээрээс Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн төлөвлөлтийн офицер, ахмад Ч.Сэр-Од ахлагчтай "Наадгай", 120 дугаар ангийн хувцасны дарга, ахлах дэслэгч С.Буянравжих ахлагчтай "Мөнгөн цагаан сум", 123 дугаар ангийн захирагчийн орлогч, ар талын дарга, хошууч И.Хатанбаатар ахлагчтай "Баруун монгол", 150 дугаар ангийн Захираганы удирдлагын тасгийн дарга, ахмад Э.Ганбаяр ахлагчтай "Цэнхэр дуулгатан", 186 дугаар ангийн Соёл хүмүүжлийн албаны дарга, ахмад Т.Заяандарь ахлагчтай "Зэндмэнэ", 350 дугаар ангийн ротын захирагч, ахмад Б.Цээноров ахлагчтай "Энхийн элч" багууд тунаж, шийдвэрлэх шатны ширүүн тулаанд хүч сорив.

Багууд өөрсдийн анги болоод ажил мэргэжлийнхээ онцлогийг Сар шинийн баяр хийгээд ахуй, соёл, зан заншил, түүх, уламжлалтайгаа хослуулан уялдуулсан мэндчилгээг бэлтгэсэн байв. Хэдийгээр ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байгаа ч цаг гарган уламжлалт тэмцээндээ өндөр ач холбогдол өгч, богино хугацаанд бүхий л нөөц боломжоо дайчлан бэлтгэсэн нь багуудын мэндчилгээнээс эхлээд үзүүлбэр бүрээс нь тод харагдаж байсныг энд тэмдэглэе. Онцолбол, Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн "Зэндмэнэ" баг нүүдэлчин монгол ахуй, түүнтэй уялдан ёс уламжлалыг нүдэнд харагдаж, гарт баригдтал мэндчилж чадсан юм. Тэд унгас ноосоо савж, шинэ эсгий хийв. Цаашлаад шинэ гэрийн найр

болгон өргөтгөв, зочин гийчнээ утган дайлав. Эдгээрийн уялдаа холбоо, утга найруулга, уран яруу үг хэллэг, тайзны засал чимэглэл бүхнээс нь монгол ахуй нэвт ханхалж байлаа. Мөн Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн "Баруун монгол" багийнхан хуур цуураа хөглөн татаж, Алтай хангайгаа магтан хайллаа, бий биелгээгээ урлан шагллалаа. Товчхондоо тэд үндэсний язгуур урлагийн амьд тоглолтоор мэндчилж, олон ястны өлгий нутгийнхан өв соёлоо хэрхэн тээж яваагаа харууллаа. Тэгвэл Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн "Мөнгөн цагаан сум" баг та бидний сэтгэлд хоногшсон "Ардын элч" киноны нэгээхэн хэсгийг Сар шинийн баяртай холбон тайзнаа амилуулж, үзэгчдийг нир хийтэл инээлгээд амжсан бол Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн "Энхийн элч" багийнхан тайз, дэлгэц хослуулсан содон мэндчилгээ дэвшүүлэн үзэгчдэд мөн л

инээд бэлэглэв. Тодотговол, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин дотнын найз хурандаа Ж.Сүх-Очирынхоо дайчин цэргүүдийг "Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр" тэмцээнд оролцож буйд баяртай байгаагаа илэрхийлэхийн сацуу тэднийг дэмжихийг уриаллаа. Тэр бээр монгол түмний уламжлалт Сар шинийн баярын тухай миний найз хурандаа Ж.Сүх-Очир надад тайлбарлаж өгсөн хэмээн "өчсөн"-ийг мэндчилгээндээ шигтгэжээ.

Тэгвэл тэмцээний ялагч Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн "Цэнхэр дуулгатан" багийн дайчид Монгол Улсынхаа их түүхийн шаргал хуудсыг эргэн сөхөж, өвөг дээдэс минь цаг хугацаа, орон зайн ямар ч нөхцөлд тусгаар тогтнолын баталгаа болсон үндэсний уламжлалт Сар шинийн баяраа хэрхэн өвлөн тээж, өртөөлөн ирснийг түүхчлэн харуулж, үзэгчдийн сэтгэлийг огшоон,



Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн "Цэнхэр дуулгатан" баг



Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн "Мөнгөн цагаан сум" баг



Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн "Зэндмэнэ" баг



Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн "Энхийн элч" баг



Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн "Баруун монгол" баг

бахархлыг төрүүлээд амжсан юм. Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн шүхэрчин дайчид буюу "Наадгай" багийнхан ч ялгаагүй өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээс, газар, тэнгэрийн шүтэлцээ холбоог өөрсдийн мэргэжлийн онцлогтой уялдуулан мэндчилсэн. Товчхондоо шигшээ багууд үнэхээр шилдэг байж үзэгчид, шүүгчдийн сэтгэлийг хөдөлгөсөн, өв уламжлал хөвөрсөн үзүүлбэрүүдээр битүүний бэлгэт оройг хөглөж чадав.

Удирдамжид заагдсан даалгавруудаас овсгоо самбаа шаардсан "Шагай шүүрэх тэмцээн" болон оюун мэдлэгийн цар хүрээг нь сорьсон "Асуулт, хариултын тэмцээн"-нүүд шагуй өрсөлдөөнтэй болов. Нүүдэлчин монгол ахуйгаас урган гарч, өвгөд дээдсээс минь өдгөө бидэнд өвлөгдсөн шагайн наадгайнуудын нэг "Шагай шүүрэх" тэмцээнд баг тус бүрээс нэг оролцогч оролцон гурван тойрог наадаж, цуглуулсан шагайныхаа нийлбэрээс хамааран оноо цуглуулах хариуцлагатай үүрэг хүлээсэн болохоор өрсөлдөөн үүсэхээс ч аргагүй. Мөн багуудын ахлагч нар "Янлинхуар"-аа яггүй сайхан дуулав. Багуудын дуучид "Хандармаа", "Дүүриймаа", "Сүнжидаа", "Бүүжидмаа", "Гавалмаа", "Хоожиймаа", "Хүүхэн нанаа", "Гэвээ бүсгүй", "Цэвэр охин", "Сэндэр охин" зэрэг ардын дууны хүүхнүүдээ аргагүй сайхан амилуулав. Өгөгдсөн даалгавар бүрийн

төгсгөлд Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн "Мөнгөн цагаан сум", 350 дугаар ангийн "Энхийн элч" багууд оноо тэнцэж, тэмцээний удирдамжийн дагуу шүүгчдийн шийдвэрээр багийн ахлагч нар нэмэлт даалгавар буюу "32 цагаан лонх" тоолон Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн "Энхийн элч" баг тусгай байр, 186 дугаар ангийн "Зэндмэнэ" баг гутгаар байр, 123 дугаар ангийн "Баруун монгол" баг дэд байр, 150 дугаар ангийн "Цэнхэр дуулгатан" баг тэргүүн байрт тус тус шалгарсан юм.

Ийнхүү Монгол Улсынхаа соёлын бахархлыг тээгч энхийг сахиулагч дайчид маань улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлж, түүх, соёлынхоо үнэт өвийг хилийн чанадад түгээн дэлгэрүүллээ. Басхүү цэргийнхэн хаана ч явсан өв соёлоороо гайхуулдгийг, өрөөл бусдад үлгэрлэдгийг, юмхнаар юм хийчихдгийг, атгасан гар шиг эвлэж чаддагийг, аливаа уралдаан тэмцээнд ач холбогдол өгч, оролцвол оролцсон шиг оролцдогийг харууллаа.

Дашрамд дурдахад тус тэмцээний шүүгчээр Мотобуудлагын батальоны захирагчийн орлогч, штабын дарга, хурандаа Ц.Буянжаргал, Соёл хүмүүжлийн офицер, ахмад С.Ууганбаяр, Цэргийн цагдаагийн бүлгийн зохицуулагч, дэслэгч Б.Анхбаяр нар ажилласан юм.

Ахмад Д.МЭНДБАЯР

# ЦЭРГИЙН ГЭР БҮЛИЙН ЭГЭЛ НЭГЭН БҮСГҮЙ

Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 108 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчинд олон жил, үр бүтээлтэй хөдөлмөрлөж байгаа цөөнгүй албан тушаалтныг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн одон, медалиар шагнасан. Тэдний нэг Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн нягтлан бодогч Ж.Батхшигийг энэ удаа онцолж байна.

Тэрбээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Алтан гадас" одонгоор шагнагдсан бөгөөд Зэвсэгт хүчний санхүүгийн албанд 36 жил тасралтгүй алба хааж яваа эрхэм юм. Түүний Зэвсэгт хүчинтэй амьдралаа холбосон урт замын аялал Ардын Армийн 186 дугаар ангийн хүнсний албаны нягтлан бодогчоор ажилласнаар эхэлдэг юм. Санхүүгийн техникумыг 1983 онд төсвийн нягтлан бодогч мэргэжлээр төгссөн тэр бээр Ардын Армийн 186 дугаар ангид 1983-1990 онд хүнсний албаны нягтлан бодогч, 1990-2005 онд ангийн санхүүгийн албаны даргын туслах нягтлан бодогчоор тус тус ажиллажээ. Ингээд 2007 онд Улаанбаатар хотод шилжин ирж, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангид ажиллах болжээ. Тус ангид оператор, нягтлан бодогчийн албан тушаалд нэг жил орчим ажиллаад 2009 оноос Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн хяналтын байцаагч, нягтлан бодогчоор томилогдон ажилласан байна.

Түүний амьдралын баяр, гуниг, инээд хөөр, бүхий л дурсамж нь энэхүү ангитай салшгүй холбоотой.

Тэрбээр өөрийнхөө ажил мэргэжлийн онцлогийн тухайд дурдахдаа "Хяналтын байцаагч, нягтлан бодогч албан тушаалд ажиллахад тийм ч амар биш бөгөөд зарим хүн үүнийг хийхээс ч айдаг байсан гэж боддог. Учир нь миний хариуцах ажлын чиглэл нь

"Төрийн албаны тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулиуд, төсвийн зарцуулалт, цэргийн ар тал, хяналтын норм, журмуудыг баталсан Монгол Улсын Засгийн газрын тогтоолууд, Зэвсэгт хүчний ангиудын санхүүгийн дотоод журам зэрэг удирдлагын баримт бичигт заасны дагуу төсвийг хэмнэх, үр ашигтай зарцуулах, өр төлбөрт орохгүй байх, ажлын төлөвлөгөөнд тусгагдсан шалгалтуудыг зохих түвшинд нь явуулж, илэрсэн зөрчлийг арилгах, баримтын бүрдлүүдийг хангуулах, ажил, үйлчилгээний явцад хяналт тавих, шалгалтын явцад гэнэтийн болон хэсэгчилсэн тооллогыг хийж гүйцэтгэх зэрэг олон талт үүргийг давхар гүйцэтгэдэг байсан юм. Энэ хугацаанд ангийн санхүүгийн кассын баримт, бэлэн мөнгөний орлого, зарлагад судалгаа хийж нотломжоор баталгаажуулан ангийн захирагчийн зөвлөлд танилцуулдаг байв. Мөн эд хариуцагчдын агуулахын бүртгэл, хөтлөлт, хээрийн гаралтын үед зарцуулагдсан шатахуун, хүнс зэрэгт хяналт тавьж зохих заавар, зөвлөгөөгөөр хангаж байлаа. Ингэж дотоод хяналтыг алба, нэгжид хийхээс гадна дээд удирдлагын байгууллагуудын хяналт шалгалтад ангийнхаа санхүү бүртгэл, тайлан тооцоог амжилттай шалгуулж ирсэн. Тухайлбал, 2013 онд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан шалгалтад санхүүгийн албаа "Сайн" дүнтэй шалгуулсан. Мөн Сүхбаатар аймагт байрлах тусгай салбарт санхүүгийн баримтын шалгалтыг мэргэжлийн хяналтын байцаагчтай хамт явуулж, үр дүнг нь ангийн захирагчид танилцуулж зохих арга хэмжээг авсан. Тэрчлэн тусгай салбарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, санхүүгийн норм, хэмжээг хэрхэн мөрдөж байгааг шалган заавар, зөвлөгөө өгч, ангийн удирдлагад танилцуулж



ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазараас "Алтан гадас" одон авч байгаа нь. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

ажилласан. Энэ мэт ажиллах хугацаандаа хийж, хэрэгжүүлсэн зүйлсээсээ дурдаад байвал олон. Би Зэвсэгт хүчний 124 дүгээр анги гэсэн "нэгэн том өрх гэр"-ийн хамт олонтой 10 гаруй жил аз жаргал, амжилт бүтээлээ хуваалцан ажиллаж, амьдарч явна. Тэдгээр он жилүүдийн хугацаанд тус ангийн захирагчаар хурандаа Д.Отгонбаатар, Р.Эрдэнэбилэг, Д.Баасансүрэн, Г.Ганбат нар ажиллаж байсан ба ажиллаж байгаа. Санхүүгийн албаны даргаар хошууч Э.Мэнджаргал, ахмад Ч.Оюунцэцэг нар ажилласан юм. Хошууч Э.Мэнджаргал нь ажлаа арван хуруу шигээ мэддэг, ямар ч хүний ая эвийг олоод харилцчихдаг бөгөөд түүнтэй хамт есөн жил ажилласан. Мэндээ дарга маань тооллого,

тооцоо, тайлан балансыг яг цагт нь хийнэ. Мэргэжлийн чадвар нь үнэхээр сайн. Шинэ гарсан дүрэм, зааврууд, санхүүгийн шинэ программуудыг аль хэдийн сурчихсан цаг тухайд нь судлаад бидэнд зааж өгнө. Ийм л дарга, хамт олонтой ажиллаж байсандаа би туйлаас баяртай явдаг" хэмээн тэрээр онцлов.

Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн санхүүгийн алба хэд хэдэн алба, тасгийн данс бүртгэлийг давхар хариуцан цомхон байдлаар ажилладаг. Тус ангийн санхүүгийн албанд түүнтэй хамт нягтлан бодогч Б.Саниха, Б.Байгалмаа, Б.Учрал, кассын нярав Д.Должинсүрэн, шатахууны нярав /дараа нь номын санч/ А.Лхамханд, тусгай салбарын нягтлан бодогч Т.Жаргалмаа, Н.Бадамханд, Б.Хандармаа нар

ажиллаж байна.

Ж.Батхшиг хэлэхдээ "Манай алба улирал, хагас жил, жилийн эцсээр тооллого хийж, тайлан гаргаснаар хийсэн ажлаа тооцдог журамтай. Жил бүрийн улирлын төгсгөлөөр тусгай салбарын нягтлангууд ирж бидэнтэй тооцоо нийлнэ. Олон салбар, тасгуудын тайлан, тооцоо нийлэх гэж олон хоногийн ажил үргэлжилнэ. Хянагч нягтлангаар ажилд орж байсан би одоо цалин, туслах аж ахуй, хүнс, зэвсэг, хими, инженер зэрэг албадын данс тооцоог хариуцан ажиллаж санхүүгийн нягтлан бодох бүртгэлүүдийг зохих дүрэм, журам, зааврын дагуу хөтөлж, өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан өөрийн хариуцсан алба, салбарын тооцоог цаг хугацаанд нь бодож, идэвх зүтгэлтэй ажилласны үр дүнд өмч, хөрөнгийн ямар нэгэн зөрчил, дутагдал гаргаж байгаагүй. Хийморь нь өөдөө цэргийн алба хаагчдыг эгнээндээ багтаасан Зэвсэгт хүчний 124 дүгээр ангид ажиллаж, амьдарч байгаа маань туулсан амьдралын минь бахархал гэж сүслэн дээдэлдэг юм" гэв.

Тэрбээр цэргийн удамтай бүсгүй бөгөөд түүний аав нь эх орныхоо тусгаар тогтнолын төлөө 30 гаруй жил алба хаасан чөлөөнд байгаа хурандаа Ё.Жасрай юм. Түүний нөхөр цэргийн түүхийн ухааны доктор, бэлтгэл дэд хурандаа Л.Баяр нь Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнд ажиллаж байсан бол том хүү Б.Энх-Амгалан нь ОХУ-ын Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн их сургуульд суралцаж төгсөөд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн тусгай салбарт РЛС-ийн салааны захирагчаар алба хааж байна. Ийм л нэгэн цэргийн гэр бүлийн эгэл нэгэн бүсгүйн тухай товчхон өгүүлэхэд ийм.

Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

(Түрүүч нь 6 дахь дугаарт)

## МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ

# СТАНДАРТЧИЛАЛ БА СТАНДАРТЫН ҮНДСҮҮД

**Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний стандартчилал ба стандартын мэдлэгийг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр "Соёмбо" сонинд цуврал болгон нийтэлж байгаа "Стандартчилал ба стандартын үндсүүд"-ийн тухай сэдвийн үргэлжлэлийг танилцуулж байна.**

### Хоёр. Стандартын төрөл, ангилал

#### 2.1.Стандартчиллын баримт бичиг

#### Монгол Улсын үндэсний стандарт

-Үндэсний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

-Үндэсний стандартын үзүүлэлт шаардлага нь олон улс, бүс нутгийн стандартын шаардлагад нийцсэн байна.

-Үндэсний стандартын төслийг сонирхогч талууд зөвшилцлийн үндсэн дээр санаачлан боловсруулна.

-Үндэсний стандарт нь товчилсон тэмдэглэгээ, улсын бүртгэлийн дугаартай байх бөгөөд түүнийг баталсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

#### Монгол Улсын үндэсний стандартын ангилал

- Нийтлэг зүйл, нэр томъёо, стандартчилал, баримт бичиг;

-Үйлчилгээ, компанийн зохион байгуулалт, менежмент ба чанар, захиргаа, тээвэр, социологи;

-Математик, байгалийн шинжлэх ухаан;

-Эмнэлгийн тусламжийн технологи;

-Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийн хамгаалал, аюулгүй байдал;

-Хэмжил зүй ба хэмжилт, физик үзэгдэл;

-Нисэх онгоц ба сансрын тээврийн хэрэгслийн техник;

-Бараа сав, баглаа, боодол ба хуваарилалт;

-Хөдөө аж ахуй гэх мэт.

#### Байгууллагын стандарт

-Аж ахуйн нэгж, байгууллага нь стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан стандарт, аргачлалын дагуу стандартчиллын хуульд нийцүүлэн боловсруулсан байгууллагын стандартыг хэрэглэж болно.

-Байгууллагын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт шаардлагад нийцсэн байна.

-Үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт шаардлагыг хангаагүй стандартаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

#### Олон улсын болон бүс нутгийн стандарт

Олон улсын хэмжээнд стандартчиллын дүрэм, журам, удирдамж, зөвлөмжийг боловсруулж, хэрэгжүүлэх бүтээгдэхүүний хэрэглээний нийцтэй байдал харилцан орлуулалт, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, гадаад худалдааг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсын стандартчиллын байгууллага үйл ажиллагаа явуулдаг.

Бүс нутгийн стандартчилал нь тодорхой хэд хэдэн улсууд өөрийн үндэсний стандартыг ижилтгэх, бүтээгдэхүүний хэрэглээний нийцтэй байдал, харилцан орлуулалтыг хангах замаар нөөцийг зүй зохицтой ашиглах, худалдааг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа

чиглүүлнэ.

Олон улсын стандартын байгууллага нь стандарт боловсруулдаг бөгөөд баталгаажуулалтад оролцдоггүй, гэрчилгээ олгодоггүй.

#### Олон улсын стандартын хамрах хүрээ

-Худалдаа;

-Эдийн засаг;

-Техник;

-Шинжлэх ухаан;

-Тохирлын үнэлгээ.

#### Олон улсын стандартууд

-Байгаль орчны удирдлага "ISO-14000" бүлэг стандарт;

-Уур амьсгалын өөрчлөлт "ISO-14065" бүлэг стандарт;

-Мэдээллийн аюулгүй байдал "ISO /IEC – 27001" стандарт;

-Хүнсний аюулгүй байдал "ISO-22000" стандарт;

-Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлага "ISO-39001" стандарт;

-Чанарын удирдлагын тогтолцоо "ISO-9000" цуврал стандарт;

-Нийлүүлэлтийн сувгийн аюулгүй байдал "ISO-28000" стандарт;

-Эрчим хүчний удирдлага "ISO-50001" стандарт;

-Нийгмийн хариуцлага "ISO-26000" стандарт;

-Авлигын эсрэг удирдлагын тогтолцоо "ISO-37001" стандарт.

Стандартчиллын баримт бичиг нь Монгол Улсын стандарт, түүний үйл ажиллагааны заавар, мөрдөх хүрээг тогтоох, хэрэглэх үндсэн нөхцөл нь болдог.

Монгол Улсын стандартыг төрийн ба төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон бизнесийн байгууллага, хэрэглэгч үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

Монгол Улсын үндэсний болон байгууллагын стандартыг боловсруулах батлах тухай "Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ итгэмжлэлийн тухай хууль", Монгол Улсын үндэсний стандартчиллын тогтолцоо 1 дүгээр хэсэг "Техникийн ажлын журам" MNS 1-1:2006, 2 дугаар хэсэг "Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм" MNS 1-2:2006-д заасан.

#### 2.2.Стандартын төрөл, агуулгын ангилал

-Суурь стандарт;

-Нэр томъёоны стандарт;

-Шинжилгээний аргын стандарт;

-Үйл явцын стандарт;

-Үйлчилгээний стандарт;

-Бүтээгдэхүүний стандарт;

-Нийцтэй байдлын стандарт;

-Тодорхой өгөгдлийн стандарт.

#### 2.3.Стандартын техникийн шаардлага, нөхцөл

-Бүтээгдэхүүнийг бэлтгэх, нийлүүлэх, хүлээн авах, ашиглах, түүний чанарыг шалгах арга, тэмдэглэлт, савлалт, тээвэрлэлт, хадгалалт, иж бүрдэл болон баталгаа гаргахад тавигдах техникийн шаардлагыг тогтооно.

-Стандартын техникийн заагдсан шаардлага

тавигдаагүй үед техникийн нөхцөлийг тогтооно.

-Стандартын техникийн ерөнхий шаардлага нь бүтээгдэхүүний шинж чанар, хэрэглэгчийн шаардлагад тохирох эсэх, бүтээгдэхүүний чанар найдвартай байдлыг тогтооно.

-Стандартын үзүүлэлтүүд ба хэмжээг тухайн бүтээгдэхүүний ашиглалтын шинж чанарыг үндэслэн хэмжээний дараалал болон бүтээгдэхүүний үйлдвэрлэх төсөл, хэлбэр, маяг, загвар, маркад тохируулан тогтооно.

-Стандартын үндсэн үзүүлэлтүүд ба хэмжээг бүтээгдэхүүний хэлбэр, маяг, ангилал, ашиглах шинж чанарыг үндэслэн техникийн дэвшил, хөгжилд хүргэх шинэ төрлийн бүтээгдэхүүн гаргахад тогтооно.

-Бүтээгдэхүүний тодорхой хэлбэр, маяг, хэмжээ, загварыг боловсруулах үед бүтээгдэхүүний харилцан орлуулалтыг хангах, ижилтгэх зорилгоор стандартын зохион бүтээлт, үндсэн хэмжээ, төрлийг тогтооно.

-Стандартын марк /шошго-үг материал, түүхий эдийн химийн бүрдэл болон шошгын тэмдэглэгээний дагуу тогтоож бусад тохиолдолд ашиглалтын шинж чанарыг үндэслэнэ.

-Тодорхой хэлбэрийн бүтээгдэхүүнийг хүлээн авахад, түүний тоо, чанарын нэгдмэл байдлыг хангах зорилгоор хүлээн авах журмыг стандартаар тогтоож болно.

-Стандартыг хянах арга нь бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийн үнэлгээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, тодорхой шинж чанарыг хянахдаа туршилт, дүн шинжилгээ, хэмжилт хийнэ.

-Стандартаар бүтээгдэхүүнийг тэмдэглэх, савлах, тээвэрлэх, хадгалахад тавигдах шаардлагыг тогтооход бүтээгдэхүүний шинж чанар алдагдахгүй байдлыг хангана.

-Стандартыг ашиглах, өөрчлөлт оруулахад тухайн бүтээгдэхүүний аюулгүй байдал, ажиллах чадварын горим болон тодорхой нөхцөлийг хангах байдлыг харгалзан тогтооно.

-Стандартын технологийн үйл явц нь бүтээгдэхүүний чанарын түвшинг хангах болон үйлдвэрлэлт, дэвшилтэт технологи нэвтрүүлэх зорилгоор тодорхой төрлийн бүтээгдэхүүнийг бэлтгэх арга, техник хэрэгсэл, технологийн хяналтыг хэрэгжүүлнэ.

-Ерөнхий техникийн ба зохион байгуулалтын аргын стандартуудыг төрлөөр нь ангилах боломжгүй байдаг. Тухайлбал ерөнхий норм, чанарын үзүүлэлт, тооцох арга, зураг төсөл, ангилал, кодлох тэмдэглэгээ, тодорхойлолт, физик хэмжигдэхүүний нэгжүүд, аюулгүй байдлын шаардлага гэх мэт болно.

—Стандартуудын шинж чанар, өгөгдөхүүнийг урьдчилан харж /стандарт хэрэглэх журам, шалгах арга, техникийн шаардлага, тэмдэглэгээ, савлалт, тээвэрлэлт, хадгалалт/, дараагийн стандартуудыг боловсруулахад ашиглах, шинээр стандарт боловсруулахад ашиглана.

Тухайлбал бүтээгдэхүүнийг шалгах аргын стандартад тусгайлсан аргыг тогтоох бусад төрлийн стандартад бүтээгдэхүүний онцлог, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгах хэрэгтэй байдаг.

Бэлтгэл хурандаа Ц.ДОРЖХҮҮ

ЦЭРЭГ-УРАН ЗОХИОЛ

Сонины энэ дугаарт Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, яруу найрагч, чөлөөнд байгаа хурандаа Гомбын ГАНБАТЫН уран бүтээлийн дээжээс нийтэлж байна. Өнгөрсөн зууны 1960-1990 оны дунд үе хүртэлх хугацаанд Ардын Армийн нэгтгэл, ангиудад Хувьсгалт залуучуудын эвлэлийн хорооны дарга, батальон, хороо, дивизийн

улс төрийн хэлтсийн дарга, өнөөгийн Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын даргаар ажиллаж байсан түүний ажил, амьдралын арвин түүхийг мэдэх хүн олон биз ээ. Тэр бээр өөрийн мэргэжил, ур чадвар, унаган авьяасаа хөгжүүлэн хэдэн арваар тоологдох дууны шүлэг, яруу найргийг туурвиж, олны хүртээл болгосон уран бүтээлч юм.

Чөлөөнд байгаа хурандаа Г.Ганбат энэ хугацаанд “Цэргийн чуулга-70”, “Цэргийн хүүгийн бодол”, “Эх орны энхийн манаанд”, “Миний амьдрал”, “Цэргийн чуулгынхан”, “Дэлхийд данстай Монгол цэрэг” зэрэг арав гаруй номыг өлгийдөн авч, өөрийн уран бүтээлийн цэнгүүнийг хэдэнтээ зохион байгуулаад байгаа ажээ.

ХАА Ч ЯВСАН ХАМТ ШҮҮ, ЭЭЖЭЭ

Хөгжим: УГЗ Д.ДОРЛИГ

Саран, наран мандсан дэлхийдээ Сар, жилүүд урсан өнгөрөхөд Санчигны үсэнд чинь хяруу унаж Сайхан залуу нас нь алсран одно Хаа ч явсан ээж, хүү хоёр Хан хорвоод амь нэгтэй шүү, ээжээ Үүрийн гэгээнээс үдэш хүртэл Үрийнхээ төлөө сэтгэл алдран Бурхан, тэнгэртээ цацлаа өргөсөн Буянтай буурал ээж минь Хаа ч явсан ээж, хүү хоёр Хан хорвоод амь нэгтэй шүү, ээжээ Уруудаж, буруудаж явахдаа хүү нь Ухаант хайртай ээжийгээ гомдоосон бол Ариухан сэтгэлтэй ээж таныхаа Ачийг нь хариулан баярлуулах сан даа Хаа ч явсан ээж, хүү хоёр Хан хорвоод амь нэгтэй шүү, ээжээ



МОНГОЛ МИНЬ

Хүннү, Чингисийн үеэс цуутай Хөрст дэлхийн талыг эзэгнэж явсан Хүмүүн төрөлхтний түүхэнд алдаршсан Хүчирхэг Монгол минь үү зээ Морин дэл дээр өсөж, өндийсөн Морин хуурын аялгуундаа уярсан Монголоороо бахархан омогшсон Малчин удамтай Монгол түмэн минь үү зээ Тал, хангай, говь хосолсон Тансаг эрдэнэсээр элбэг баян Танан цагаан гэрүүд ярайсан Таван хошуу мал нь бэлчсэн Морин дэл дээр өсөж өндийсөн Морин хуурын аялгуундаа уярсан Монголоороо бахархан омогшсон Малчин удамтай Монгол түмэн минь үү зээ Арвин дэлхийн хаана ч явсан Алаг зүрхэнд уяатай явдаг Аугаа Чингисийн өлгий нутаг аа Амин хайртай Монгол минь үү зээ Морин дэл дээр өсөж өндийсөн Морин хуурын аялгуундаа уярсан Монголоороо бахархан омогшсон Малчин удамтай Монгол түмэн минь үү зээ 2019.12.20



МОНГОЛ ЦЭРЭГ

Дэлтэй жижигхэн Монгол морьтойгоо Дэлхийн түүхэнд мөнхрөн алдаршсан Өвөг дээдэс Хүннү Чингисийн Өрлөг баатруудын гавьяаг залгасан Эх оронд аюул учрахад Энэ биеэ зориулах тангарагтай Эрэлхэг дайчин Монгол цэрэг ээ Хиагт, Алтанбулаг, Халхын гол Хамаг даваа, Хянган, Жанчүүд Баатарлаг үйлстэй эрэлхэг цэрэг ээ Эх оронд аюул учрахад Энэ биеэ зориулах тангарагтай Эрэлхэг дайчин Монгол цэрэг ээ Олон улсын энхийн үйлст Орон орны цэргүүдтэй хамт Алдар гавьяагаа дэлхийд гайхуулсан Азийн Монголын домогт цэрэг ээ Эх оронд аюул учрахад Энэ биеэ зориулах тангарагтай Эрэлхэг дайчин Монгол цэрэг ээ 2019.12.20



АЧИЙГ НЬ ЯАЖ ХАРИУЛСАН БИЛЭЭ

Арван сар тээж төрүүлсэн Ангир уургаа шимүүлэн өсгөсөн Алаг хорвоогийн амьдралд хүргэсэн Ачтай, буянтай, бурхан ижийнхээ Ачийг нь яаж хариулсан билээ Асарч, хүндэлж чадсан билүү Ирдэг буцдаг энэхэн хорвоод Ижийгээс минь илүү ачтан үгүй Хатуу ширүүн амьдралын нугачаанд Хэнзхэн үрсээ хүний зэрэгт хүргэх гэж Хорвоогийн сар, жилүүдийг туулан Халуун залуу насаа зориулсан ижийнхээ Ачийг нь яаж хариулсан билээ Асарч, хүндэлж чадсан билүү Ирдэг, буцдаг энэхэн хорвоод Ижийгээс минь илүү ачтан үгүй Түмэн бээрийн тэртээх алсаас Төрүүлж өсгөсөн үрсээ санан Өглөө, үдэшгүй сүүн цацлаа Халуун залуу насаа зориулсан ижийнхээ Ачийг нь яаж хариулсан билээ Асарч, хүндэлж чадсан билүү Ирдэг, буцдаг энэхэн хорвоод Ижийгээс минь илүү ачтан үгүй Зөв, бурууг ухааруулж өгсөн Зөөлөн сэтгэлт ижийн минь сургаал Насан туршид биднийгээ ивээж Нар шиг ариун хайранд нь нялхарч явлаа Ачийг нь яаж хариулсан билээ Асарч, хүндэлж чадсан билүү Ирдэг, буцдаг энэхэн хорвоод Ижийгээс минь илүү ачтан үгүй 2020.01.11

ХАЛХЫН ГОЛЫН ДУРСАМЖ

Хөгжим: МУСТА Д.ОТГОНТОГООЛ

Дарийн утаа тэнгэр, газар бүрхсэн Дайнтай тэр жил Халхын гол Догшрон, эргэлдэн шуугиж байхад Дайчин эрчүүд тулаанд мордсон юм Дайны аюулыг сөрөн давшсан Дайчин цэрэг эрсийн гавьяаг Эх орон, эгэл олон чинь Эгнэгт бахархан санан дурсана Эх орон, Монгол түмнийхээ төлөө Эр зоригийн гайхамшиг үзүүлэн Асгарах цус, амиа үл хайрлан Агуу их ялалтыг дархалсан юм Дайны аюулыг сөрөн давшсан Дайчин цэрэг эрсийн гавьяаг Эх орон, эгэл олон чинь Эгнэгт бахархан санан дурсана Дайн дуусаад олон намар өнгөрсөн ч Дархан хилийн домогт Халхын гол Дайчин баатруудаа дурсан, дурсан Долгиолон мяралзан намуухан урсана Дайны аюулыг сөрөн давшсан Дайчин цэрэг эрсийн гавьяаг Эх орон, эгэл олон чинь Эгнэгт бахархан санан дурсана



МОНГОЛ ОМОГШИЛ

Оройн дээд шүтээн Бурхан халдун уулаа түшин Онон мөрний уснаасаа ундаалан ариуссан Омгolon хурдан хүлгийнхээ дөрөөн дээрээс Олон аймаг, улсаа нэгтгэн захирсан Тэмүүжин Бүх цэргийн хар сүлднийхээ намираан дор Бүрэн эрхт Монголоо байгуулан омогшсон Эзэн Чингис хааны алдар мандан бадартугай Их Монгол Улсын сүр хүч бүү алдартугай Хурай, хурай, хурай Дээвэр тусгаар Монгол Улсынхаа нэрийг Дэлхийн сонорт хүргэж, суу алдраа дуурсгасан Таван тивд нэр нь мөнхөрсөн Чингис хаанаараа Талын Монголчууд бид бахархахгүй гээд яах юм бэ Бүх цэргийн хар сүлднийхээ намираан дор Бүрэн эрхт Монголоо байгуулан омогшсон Эзэн Чингис хааны алдар мандан бадартугай Их Монгол Улсын сүр хүч бүү алдартугай Хурай, хурай, хурай Мянга мянган жил дэлхий даяараа Морьтон Монголоо магтан дуулуулсан Мянганы Чингис хаанаараа бид омогшилгүй яах юм бэ Монголынхоо Чингис хаанаараа бид алдаршихгүй яах юм бэ Бүх цэргийн хар сүлднийхээ намираан дор Бүрэн эрхт Монголоо байгуулан омогшсон Эзэн Чингис хааны алдар мандан бадартугай Их Монгол Улсын сүр хүч бүү алдартугай Хурай, хурай, хурай Есөн өрлөг зоригт баатруудынхаа хамт Ертөнцийн талыг эзэгнэн явсан Чингис хаан Дайны талбарт дайсныг ялан дийлсэн Даян дэлхийд алдар цуутай Чингис хаан Бүх цэргийн хар сүлднийхээ намираан дор Бүрэн эрхт Монголоо байгуулан омогшсон Эзэн Чингис хааны алдар мандан бадартугай Их Монгол Улсын сүр хүч бүү алдартугай Хурай, хурай, хурай



ХҮҮХДҮҮДЭЭ ЗАХИХ СУРГААЛ ҮГС

Зулай, зулайгаа дарж төрсөн охид минь Зуу зуун жил голомтыг минь залгах үрс минь Алтан дэлхийд амьдрах цаг хугацаандаа Ахмад настан, ахан дүүсээ хайрлаж яваарай Аав, ээжийн танхилхан охид минь Амьдрал цэцэглэх ариухан үрс минь Эрдэм ухааныг эрхэмлэж яваарай Ээж, ааваа хүндлэн, халамжилж яваарай Аав, ээжийн гэрээс өрх тусгаарлан Айлын бэр, хүний хань болсон цагт Амьдралын эрээнтэй бараантай замд Алдаж, эндэж явахдаа хэн хэнээ түшиж яваарай Өнгөт хорвоод залуу нас богинохон ч Он жилүүд ээлжлэн улиран өнгөрнө Нэг л мэдэхэд настан буурал аав ээж чинь Нөгөө ертөнцөд нисэн одно Аав ээжийг чинь орлож үлдсэн Ах, эгч нарынхаа үгийг сонсож Хагацал, зовлонг хамтран хуваалцаж Хань, нөхөр, үр хүүхдээ халамжилж яваарай Эвтэй найртай амьдарч явах чинь Ээж, аавийн сургаалыг эрхэмлэхээс шалтгаална Ажил хөдөлмөрийг дээдлэн явбал Амьдрал ахуй чинь дэвжин дээшилнэ Үр, ач зээ нар чинь Өсөн өндийж, өнөр өтгөн болно Өөрсдөө та нар өвөө, эмээ нар болно Өргөн дэлхийд бүүвэйн дуутай жаргана Амьдрал гэдэг чинь мөнхөд цэцэглэж Алтан дэлхийд удам залгах үр, ач нар чинь Мянга мянган жил гал голомтыг чинь сахиж Монголын үрс өсөн үржих болно



Чөлөөлөх дайны 75 жилийн ойд

ЯЛАЛТАД ЯМАГТ ХАМТДАА

Дөчин нэгэн оны дайн эхлэхэд Дэлхийн дөрвөн зүг, найман зовхист Аюулт дайны харанга дэлдэхэд Агуу Орос орон нэгдэн босов Энэ дайн зөвхөн Оросынх байсангүй Эрсэн тэмцсэн дэлхийн дайн байлаа Дөрвөн жил цусан зам татуулсан Дөрвөн жил сая сая хүмүүсийн Алтан амь, амьдралыг авч одсон Аюулт дайн-Дэлхийн дайн байлаа Хагацал, өнчрөл, үхэл дагуулсан Хар дайны аймшигт он жилүүдэд Атаат дайсан фашизмыг сөрөн Анд Оросын арми тулалдсан Хар хэрээ шиг фашистын онгоцнууд Хан тэнгэрээс үхлийн бөмбөг чулуудаж Хас тэмдэгтэй хуягт танкнууд Хот, тосгоныг газрын хөрстэй тэгшилж Аадар шиг асгарах суман мөндөр Аюул тээсэн тэсрэх бөмбөгнүүд Үхэл дагуулсан тасралтгүй дэлбэрч Үй олон хүмүүсийн амийг авч одсон ч Эх орон, эрх чөлөөгөө хамгаалсан Эр цэрэг, эгэл олныг сөхрөөж чадаагүй юм Үнс нурам боргисон газрын хөрс Үхэж үрэгдсэн хүмүүсийн цогцсоор дүүрч Өнчирч, хагацсан бүсгүйчүүд, хүүхдүүд Өлсгөлөн, өвчин зовлонд нэрвэгдсэн Энхрий хүүгээ фронтод үдсэн эхчүүд Эр нөхрөө дайнд явуулсан бүсгүйчүүд Өдөр бүр дайны мэдээ сонсож Өнчин дэрэн дээрээ нулимстай байсан Орчлон хорвоогийн эрх чөлөө, энхийн төлөө Олон сая хүн ардын аз жаргалын төлөө Агуу их Оросын ард түмэн Алдарт Улаан арми тулалдсан юм Энэ дайн зөвхөн Оросынх байсангүй Эрсэн тэмцсэн Дэлхийн дайн байлаа Аюулт дайны хүндийг Орос цэргүүд үүрч Асгарах цус, алтан амь, амьдралаараа Даян олонд энхийг тунхаглан зарласан нь Агуу их Оросын ард түмэн байлаа Алдар гавьяатай Улаан арми байлаа Энэ дайнд Оросын ард түмэн ялан дийлж Энэ ялалтаар улс түмэн аврагдсан юм Ялалт ямар их үнээр ирснийг Ялсан орос цэрэг эрс л хэлнэ Эх орон ямар их үнэтэй байдгийг Эх орноо хамгаалсан цэрэг эрс л мэднэ Дэлхийн дайнтай он жилүүдэд Дэлгэр Монголын морьтон ардууд Ялгуулсан Улаан армийн дайчидтай Ялалтын өдрийг хүртэл хамт байсан Аюулт дайны эхний өдрөөс эхлэн Азийн Монголын түмэн олон Бүхнийг фронтод, ялалтын төлөө Бүсээ чангалан нойргүй хонож Баатарлаг Улаан армийн дайчдад Бахдам ялалт, амжилт хүсэн Бэлгийн цуваа хуримтлуулан илгээж Бие сэтгэлээрээ тусалж байсан Талын Монголын малчин ардын Тахийн удамт Монгол адуу Оросын уудам нутгийг туулан Орос цэргүүдтэй Берлинд хүрч Ялалтын жимийг гаргаж явсан Яруу алдрын дайчин түүхтэй Хөх Монголын малчин ардууд Хөрөнгө мөнгө цуглуулан нийлүүлж Хувьсгалт Монголын танкийн цуваа Хурдан онгоцны эскадриль байгуулан Атаат дайсан фашизмтай тулалдан Алдар гавьяагаа мандан бадруулж Агуу их ялалтын уухайг Ахан дүүстэйгээ цуурайтуулж явсан Дөчин таван оны намар Дайчин Монгол цэрэг эрс Агуу их Оросын ард түмэн Алдарт Улаан армийн дайчидтай Алс Дорнодод атаа дайсантай Ариун үнэний төлөө тулалдан Ахан дүү Өвөр Монгол, Хятадыг чөлөөлөхөд Аагим халуун говь, хянганд дайцсан юм Хянганы даваанд тулалдаж ирсэн Хатан зоригт Монгол цэрэг эрс Жанчхүүгийн бэхлэлтэд давшиж явсан Жанжны тушаалтай эрэлхэг дайчид Алтан амиа эх орондоо өргөсөн Алдар гавьяатай хөвгүүд, охид минь Эх орондоо үнэнчин тангарагтай Эрэлхэг Монгол баатрууд байсан юм Говь, хянганд баатарлагаар тулалдсан Гавьяа байгуулж мөнхөрсөн баатрууд минь Жанчхүү, Хаалган, Жэхэгээс Жагсаалдаа эргэж ирээгүй зоригтнууд минь Дайчин цэрэг эрсийн халуун амиар Дархан ялалт, энхийг авчирсан юм Дайны аюул гэж юу байдгийг Дайчин эрчүүд биеэрээ амссан юм Ялалтын баярын өдөр бүхэнд Ялгуулсан баатарлаг гавьяаг тань Эх орон, эгэл олон чинь санан Эрэлхэг баатруудаа дурсаж байна Эр цэрэг чи өнөөдөр амьд байна Эх орондоо алдар нь өөдөө байна Ариун үйлс, эр зоригор чинь Ард түмэн чинь бахархаж байна Ялалт авчирсан цэрэг эрсийн Яралсан жагсаалыг бахдан харахад Дөчин таван оны ялалтын жагсаал Дөнгөж өчигдөрхөн мэт санагдаж байна Агуу эх орны дайны ялалтаар Анд Орос, Монгол дайчдын гавьяагаар Нарлаг Монголд минь энх цаг ирж Найрсаг ард олон минь жаргалтай байна

УРИАЛГА

Монгол Улсын Зэвсэгт хүчин 2003 оноос энхийг дэмжих ажиллагаанд цэргийн бага илгээж үүрэг гүйцэтгүүлж эхэлсэн нь манай улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүн орон гэдгээ нотолж, олон улсын түвшинд үүрэг гүйцэтгэх чадамж бүхий Зэвсэгт хүчинтэй улс болохоо батлан харуулсан чухал үйл явдал болсон юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөөлөн үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагчдын үйл хэрэг, байгуулсан гавьяа зүтгэлийг мөнхжүүлж, иргэд, хүүхэд, залуучуудад сурталчлан таниулах, тэдэнд эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор "Олон улсын Энхийг сахиулагчдын өдөр"-ийг тохиолдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Монгол цэрэг-Энхийн төлөө" дурсгалт цогцолборын шавыг тавьж, бүтээн байгуулалтын

ажлыг эхлүүлсэн билээ. Уг бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний нийт ахлагч нарын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн тэдний идэвх санаачилгыг нь дэмжих зорилгоор сайн үйлсийн хандивын аяныг өрнүүлж байна.

Иймд "Монгол цэрэг-Энхийн төлөө" цогцолборын хөшөө, дурсгалыг босгох ажилд хувь нэмрээ оруулахыг Зэвсэгт хүчний ахлагч нартаа уриалж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН АХЛАГЧ, ТЭРГҮҮН АХЛАГЧ Б.ГАНТӨМӨР

ЭМГЭНЭЛ

ЧИМЭДЦЭРЭНГИЙН САМБУУ /1933-2020/



Дайнд оролцогчдын Монголын хорооны дарга асан, төр, цэргийн нэрт зүтгэлтэн, чөлөөнд байсан хошууч генерал Ч.Самбуу тэнгэрийн орноо залран бидний сэтгэлд гүн харамсал үлдээж, сэтгэлийн зул болон мөнхөрлөө.

Ч.Самбуу нь 1933 онд Өмнөговь аймгийн Аргалант, одоогийн Ханхонгор сумын нутагт төрсөн бөгөөд 1953-1956 онд Цэргийн ерөнхий сургууль, 1956-1959 онд ЗХУ-д Цэргийн химийн дунд сургууль, 1962-1968 онд ЗХУ-ын Москва хотноо Цэргийн хими хамгаалалтын академи, 1976-1978 онд К.Е.Ворошиловын нэрэмжит Зэвсэгт хүчний Жанжин штабын академид тус тус суралцаж төгссөн юм.

Хошууч генерал Ч.Самбуу нь 1953 онд цэргийн албанд татагдан ирсэн бөгөөд 1959-1961 онд химийн тусгай ротод салааны дарга, 1961-1962 онд нэгдүгээр мотобуудлагын хороонд химийн ротын дарга, 1968-1970 онд Ардын цэргийн Жанжин штабт химийн албаны офицер, 1970-1971 онд БХЯ-ны Байлдааны бэлтгэл хэлтсийн орлогч, 1971-1976 онд Ардын Армийн Химийн тусгай батальоны захирагч, 1978-1979 онд Цэргийн ерөнхий дээд сургуулийн захирлын орлогч бөгөөд Сургалтын хэлтсийн дарга, 1979-1983 онд Цэргийн нэгдсэн дээд сургуулийн захирал, 1983-1986 онд ЗХЖШ-ын Байлдааны бэлтгэлийг удирдах газрын орлогч, хэлтсийн дарга, Химийн цэргийн дарга, хэлтсийн дарга, 1986-1990 онд Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч бөгөөд Цэргийн тагнуулын газрын даргаар ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан юм. Тэр бээр 1990-2006 онд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Ахмадын хорооны даргаар ажиллаж байгаад 2007 оноос Дайнд оролцогчдын Монголын хорооны даргын өндөр хариуцлагатай албыг хашиж байлаа.

Ч.Самбууд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1981 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 82 дугаар тогтоолоор хошууч генерал цол хүртээсэн бөгөөд түүний хөдөлмөр, зүтгэлийг нь төр, засгаас өндөрөөр үнэлж Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон, "Алтан гадас" одон болон бусад медалиар шагнасан юм.

Талийгаачийн Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэн бэхжүүлэх, залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйлсэд оруулсан бүтээлч хувь нэмэр, ахмад дайчдынхаа төлөө хийж хэрэгжүүлсэн идэвх санаачилгатай үйл ажиллагаа, гэгээн дүр төрх, хүнлэг, энэрэнгүй, ажилсаг, хичээнгүй, нийтэч зан чанар нь бидний сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ, ЦЭРГИЙН ТАГНУУЛЫН ГАЗАР, ТӨРЛИЙН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, МОНГОЛЫН АХМАДЫН ХОЛБОО, ДАЙНД ОРОЛЦОГЧДЫН МОНГОЛЫН ХОРОО, МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО, "МОНГОЛ ГЕНЕРАЛ" ТӨВ, БХЯ, ЗХЖШ-ЫН АХМАДЫН ХОРОО, ГЭР БҮЛ, ХҮҮХДҮҮД, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД, АНД НӨХӨД НЬ

БҮДҮҮНИЙ САНДАГ /1946-2020/

Зэвсэгт хүчний шилдэг инженерүүдийн нэг радиотехникийн чадварлаг, туршлагатай офицер, чөлөөнд байсан дэд хурандаа Б.Сандаг нь хүнд өвчний улмаас таалал төгсөж бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.



Б.Сандаг нь 1946 онд Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт Товцог гэдэг газар төрж, 1965 онд Өмнөговь аймгийн төвийн 10 жилийн сургууль, 1969 онд ЗХУ-ын Одесс хотын УАДХЦ-ийн команд-инженерийн нэгдсэн дээд сургуулийг радиотехникийн станцын засвар, ашиглалтын инженер мэргэжлээр төгссөн. Мөн 1984 онд Киев хотод шинэ загварын РЛС-ын ашиглалтын курс мөн 1990 онд Владимир хотод Радиотехникийн цэргийн төв курст тус тус суралцаж төгсчээ.

Тэр бээр 1969-2009 онд Зэвсэгт хүчний 065 дугаар ангид салааны захирагч, РЛС-ын засварын техникч, нэгдсэн засварын дарга, РЛС-ын инженер, радиотехникийн албаны дарга зэрэг албан тушаалд томилогдон ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан юм.

Б.Сандаг нь Зэвсэгт хүчинд залуу насаа зориулан залуучуудад үлгэр дууриал үзүүлсэн сурган хүмүүжүүлэгч байсан ба түүний хөдөлмөр, зүтгэлийг төр, засгаас өндөрөөр үнэлж Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одон, "Алтан гадас" одон, Цэргийн хүндэт медаль, БХЯ-ны хүндэт тэмдэг болон бусад медалиар шагнасан юм.


Түүний ажилч хичээнгүй, хөдөлмөрч, шударга зан чанар нь бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 065 ДУГААР АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН, "ЭНХ ТЭНГЭРИЙН ХАРУУЛ" ТББ, АХМАД ДАЙЧЕД, ГЭР БҮЛ, ҮР ХҮҮХДҮҮД, АХАН ДҮҮС, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД, АНД НӨХӨД НЬ

ТАЛАРХАЛ

Бидний ээж Ц.Минжид нь 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 93 насандаа өвчний улмаас бурхны оронд заларсан билээ. Үр хүүхэд, ах дүү бидэнд нөхөж баршгүй гарз тохиолдоход гүн туслалцаа үзүүлсэн Нийслэлийн болон дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабууд, Багахангай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Цэргийн штаб, Ховд аймгийн Засаг даргын тамгын газар, Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, "Ховд" их сургууль, Ерөнхий боловсролын 1, 3 дугаар сургууль, 2 дугаар сургуулийн 1982 оны 10<sup>а</sup>, 1985 оны 10<sup>б</sup>, 1989 оны 10<sup>в</sup> ангийн хамт олон болон ах дүүс, төрөл төрөгсөд, найз нөхөдөө чин сэтгэлээсээ баярлаж талархсанаа илэрхийлэн та бүхний ажил үйлс үргэлж дэвжин дээшилж, амьдрал тань аз жаргалаар дүүрэн байж, хүсэл бүхэн тань биелэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж.

Та бүхнийг хүндэтгэсэн Нийслэлийн Багахангай дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Б.Батмөнх, үр хүүхэд, ач зээ, ах дүү нар нь.



Ээжээ Та миний амьд бурхан

Сайн байна уу, ээжээ. Таныхаа амар мэндийг асууж захидал илгээж байгаадаа үнэхээр баяртай байна. Юуны өмнө тандаа удахгүй болох гэж байгаа Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийн мэндийг Зэвсэгт хүчний 120 дугаар ангиас дэвшүүлж.

Халдвараас болж 80 мянган хүн өвдсөн гэж сонссон. Тиймээс та аав, ах, өөрийгөө энэ өвчнөөс маш сайн урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваарай. Хүүдээ санаа зовоод хэрэггүй шүү. Хүү нь цэргийн ангид байгаа учраас коронавирус тусах магадлал байхгүй гэж ойлгож болно. Манай ангид өдөр бүр ариутгасан амны хаалт өгч, хоолонд орохоос өмнө гараа байнга угаадаг юм.

Мөн чийгтэй цэвэрлэгээг тогтмол, маш сайн хийдэг учраас энд коронавирус байтугай жирийн ханиад ч орж чаднахгүй. Энд нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой эрүүл чийрэг залуус эх орноо, ээж, ааваа гэсэн дүүрэн сэтгэлээр цэргийн алба нэр төртэйгөөр хааж байна. Эр хүн болсны утга учрыг эндээс л олж мэдлээ. Таныхаа халуун дулаан инээмсэглэсэн царай төрх, уянгалаг сайхан хоолой, тансаг сайхан үнэрийг их л санаж байна. Та бол энэ ертөнц дээрх миний амьд бурхан юм шүү. Намайг өдий зэрэгтэй өсгөж хүмүүжүүлсэн ачийг тань хүү нь заавал хариулна.Цэргээс халагдаж очоод тандаа жаргалын дээдийг амсуулна. Таныхаа энгэрт наалдаад хамтдаа сууна аа, ээжээ. Ээжээ хүү нь тандаа маш их хайртай шүү. Тандаа эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн өрөө.

Хоёрдугаар батареины байлдагч Б.ЭНХ-ОД

МИНИЙ ХҮҮ АЛБАА САЙН ХААГААРАЙ

Бид байлдагч Б.Энх-Одын ээж Дорнод аймгийн Баян-Уул сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга Ж.Алтанцэцэгтэй холбогдон хүүгийнх нь захидлыг уншиж мэндийг нь дамжуулсан юм. Тэрээр "Би хоёр хүүтэй. Б.Энх-Од маань миний бага хүү. МУИС-ийн гуравдугаар дамжаанд суралцаж байгаад цэргийн алба хаана гэж өөрөө шийдвэр гаргаасан. Миний хувьд жаахан дурамжан байсан, гэхдээ одоо бол зөв шийдвэр байсан гэж бодож байгаа. Сар шинийн баяраар хүү минь хоёр удаа утсаар ярьсан. "Ээж ээ, би жаахан таргалчихсан,

маш сайн байгаа" гэж байна лээ. Тангарагийн баяраар нь аав, ахтай нь хамт хүүгээ эргэж очсон. Маш сайхан ёслол болдог юм билээ. Ижилхэн хувцастай цэргүүдээс хүүгээ ялгаж таниагүй. Цог жавхаатай, биеэ даасан, цаанаа л өөр харагдсан. Ээж нь хүүгийнхээ чин сэтгэлийн үгийг та бүхнээр дамжуулан сонсоод үнэхээр их баярлаж байна. Миний хүү үеийн нөхөдтэйгөө зөтэй найртай байж албаа сайн хаагаад ээждээ ирээрэй. Хүүдээ маш их хайртай" хэмээн дамжуулсан юм.

Ээж, хүү хоёрт сайн сайхан бүхнийг хүсье.


Үндэсний бахархал, Өв соёл

Улаан армийн Жанжин штабаас

Алс дорнод дахь Зөвлөлтийн цэргийн Ерөнхий жанжин маршал Василевский 8 дугаар сарын 17-нд Японы Квантуны армийн цэргийн командлагчид уламжилсан радио мэдээ нь:

Японы Квантуны армийн штабаас радиогоор Алс дорнод дахь Зөвлөлтийн цэрэгт байлдахыг зогсооё гэж мэдэгдсэн боловч Манж дахь Японы зэвсэгт хүчин бууж өгөх тухай юу ч хэлсэнгүй байна. Бас ч Японы цэрэг Зөвлөлт, Японы фронтын хэдэн газраар эсрэг давшилтыг хийж эхлэв.

Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс "Улаан од" сонин. 1945.08.18. Дугаар 176



ЗӨВЛӨМЖ, ЗӨВЛӨГӨӨ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБАНААС СЭРЭМЖЛҮҮЛЖ БАЙНА

Замын хөдөлгөөн нээсэн энэ өдрүүдэд нийт нутгаар цас орж, цасан шуурга шуурах төлөвтэй байгаа тул доорх зүйлсийг мөрдөж замны хөдөлгөөнд оролцохыг алба хаагчдад анхааруулж байна.

- > Анги, байгууллагаас орон нутгийн замд үүрэг гүйцэтгэх тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж гарах;
> Автомашины хөдөлгөөн ихтэй байх тул аль болох гүйцэж түрүүлэх үйлдэл хийхгүй байх;
> Шөнийн цагт холын гэрлээ шилжүүлэх;
> Олон цагаар автомашин жолоодохгүй байх (Хоёр цаг тутамд бууж биеийн чилээгээ гаргах);
> Хамгаалах бүсээ бүсэлж бага насны хүүхдийг зориулалтын суудалд тээвэрлэх;
> Суудлын тооноос илүү хүн тээвэрлэхгүй байх;
> Анги, байгууллагаас 80 буюу түүнээс дээш километр зайд хөдөлгөөнд оролцохдоо Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанд бүртгүүлэн тээврийн хэрэгслээ шалгуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцах шаардлагатай.
Хөдөө, орон нутгийн Зэвсэгт хүчний анги, байгууллага заавал утсаар мэдэгдэж байхыг анхааруулж байна.

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагч, дэслэгч Э.ӨНӨБОЛД

АМЬСГАЛЫН ЗАМЫН ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ, ХООЛОЙ ЗАЙЛАХ УУСМАЛАА БЭЛДЭЦГЭЭ

Infographic showing water purification methods: 1. Сармисны уусмал (500ml water, 4-5 salt tablets, 5 min wait, 15 min boil); 2. Нимбэгийн уусмал (250ml water, 1 lemon slice, 5-10 min wait); 3. Содын уусмал (100ml water, 2g soda, 1 min wait); 4. Давсны уусмал (95ml water, 5g salt, 10 min wait); 5. Давсны уусмал (1 liter water, 50g salt, 15-20 min wait, 5 liter water, 15 min boil).

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч Хурандаа Батжаргалын ОТГОНБАЯР
Эхийг "Соёмбо" сонини редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариулна.
\*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
\*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Mil\_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029